



**MNS ISO 39001:2014 “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ (ЗХАБ)
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО” НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН
ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН**

Тайлан хянсан:

С.ДАВААНЯМ Багийн ахлагч

Тайлан боловсруулсан:

Л.ТУНГАЛАГ (Сургагч багш)

2024 оны 03-р сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

1. Ерөнхий зүйл.	3
2. Хийж гүйцэтгэсэн ажлын талаар	3
Хавсралт 1. Ажлын төлөвлөгөө	10
Хавсралт 2. Стандартын төсөл	13
Хавсралт 3. Орчуулгын засварт өгсөн саналын товчоо	57
Хавсралт 4. Сургалтын гарын авлагын нүүр	61
Хавсралт 5. Модуль 1. Танилцуулах сургалтын хөтөлбөр	62
Хавсралт 6. Модуль 4.1. Сургагч багшийн сургалтын хөтөлбөр	66
Хавсралт 7. Модуль 3. Дотоод аудитын сургалтын хөтөлбөр	73
Хавсралт 8. Модуль 4.2. Зөвлөхийн сургалтын хөтөлбөр	78
Хавсралт 9. Модуль 4.3. Тэргүүлэх аудиторовын сургалтын хөтөлбөр	83
Хавсралт 10. Сургалтын бүртгэл	88

MNS ISO 39001:2014 “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ (ЗХАБ)
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО” НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН
ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

2024 оны 03-р сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ЗОРИЛГО: MNS ISO 39001:2014 “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ (ЗХАБ) УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО” НЭВТРҮҮЛЭХ

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: Удирдах урлаг хөгжил ТББ

1. Ерөнхий зүйл.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-тай 2023 оны 10-р сарын 16-ны өдөр байгуулсан 2023/03-128 дугаартай гэрээгээр байгуулсан MNS ISO 39001:2014 “Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ) удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо” нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын эцсийн шатны тайланг боловсруулав.

2. Хийж гүйцэтгэсэн ажлын талаар

2.1 Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-тай байгуулсан 2023/03-128 дугаартай дугаартай гэрээний дагуу MNS ISO 39001:2014 “Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ) удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо” нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварын хүрээнд хийж гүйцэтгэх Ажлын төлөвлөгөө **(Хавсралт 1)**-г боловсруулж дараах ажлыг хийж гүйцэтгэв:

2.2 Сургалтын төлөвлөгөөний дагуу дараах 5 төрлийн сургалтыг 1-р сарын 29-ний өдрөөс 4-р сарын 1-нийг хүртэл дараах хуваарийн дагуу зохион байгуулав. Сургалтыг танхим, цахим, бие даалт гэсэн хэлбэрүүдийг хослуулж хуваарийн дагуу зохион байгуулсын Хүснэгт 1-ээс үзнэ үү.

2.3 Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад ашигласан материалыг Хавсралт 11-д оруулав.

2.4 Ажлын даалгаварын хүрээнд Захиалагчид дараах материалыг хүлээлгэж өгөв.

1. ISO 39001 Стандартын хяналт хийсэн хувилбар (Хавсралт 2)
2. ISO 39001 Стандартын сургалтын гарын авлага (Хавсралт 4),
3. Сургалтын 5 хөтөлбөр. (Тайлангийн Хавсралт 5-9).

Хүснэгт 1. Сургалтыг зохион байгуулсан огноо, сургалтын хэлбэр

№	Сургалтын нэр	Сургалтын хэлбэр	Сургалтын огноо
1	Модуль 1. MNS ISO 39001:2014 стандартын Танилцуулах сургалт	Танхим	1-р сарын 29
2	Модуль 3. MNS ISO 39001:2014 стандартын Дотоод аудитын сургалт	Танхим, Дадлага	1-р сарын 31-2-р сарын 2
3	Модуль 4.1 MNS ISO 39001:2014 стандартын Сургагч багшийн сургалт	Танхим, Дадлага	2-р сарын 20-26
4	Модуль 4.2 MNS ISO 39001:2014 стандартын Зөвлөхийн сургалт	Танхим, Дадлага	2-р сарын 26-3-р сарын19
5	Модуль 4.3 MNS ISO 39001:2014 стандартын Аудитор/Тэргүүлэх аудиторын сургалт	Танхим, Дадлага	3-р сарын 19-29

2.3 Сургалтанд давхардсан тоогоор нийт 181 хүн хамрагдаж гэрчилгээ авсан. Сургалтын модуль тус бүрт хамрагдсан хүмүүсийн жагсаалт, ажлын даалгаварт өгсөн тоо, биелэлтийн байдлыг Хүснэгт 2-оос үзнэ үү.


Хүснэгт 2. Сургалтанд хамрагдсан байдал

Сургалтын нэр	Хамрагдсан	Даалгавар	Биелэлтийн хувь
Модуль 1. MNS ISO 39001:2014 стандартын Танилцуулах сургалт	45	50 хүртэл	100%
Модуль 3. MNS ISO 39001:2014 стандартын Дотоод аудитын сургалт	45	40 хүн	100%
Модуль 4.1 MNS ISO 39001:2014 стандартын Сургагч багшийн сургалт	34	30 хүн	100%
Модуль 4.2 MNS ISO 39001:2014 стандартын Зөвлөхийн сургалт	34	20 хүн	100%
Модуль 4.3 MNS ISO 39001:2014 стандартын Аудитор/Тэргүүлэх аудиторын сургалт	23	20 хүн	100%
Нийт	181		


2.4 Бүх сургалтыг Google Classroom орчинд бэлтгэж, суралцагчдад дараах орчныг бүрүүлж ажилласан:

- 1) сургалтын явцад шаардлагатай видеохичээлүүдийг бэлтгэж ангид байршуулсан
- 2) хичээлийг судлахад шаардлагатай мэдээлэл, материалыг тухай бүр хангасан,
- 3) цахим орчинд багаар болон оролцогч тус бүр бие дааж ажиллах боломжтой Google doc болон Google sheet ашигласан;
- 4) Суралцагчид багштайгаа болон өөр хоорондоо цахим орчинд мэдээлэл дамжуулж сургалтын цагийг оновчтой ашиглаж байсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн сургалт
M 1, ISO 39001:2012



2.5 Сургалтын явцын зургийг эвлүүлж танилцуулж байна:






Модуль 4-1 сургалт. Сургагч багшийн сургалт



Модуль 4-2 сургалт. Зөвлөхийн сургалт



Модуль 4-3 сургалт. Тэргүүлэх аудиторын сургалт



2.6 Гэрээний хавсралтаар баталсан ажлын даалгаварын дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг даалгавар тус бүрээр гаргаж доор танилцуулж байна.

1	<p><i>ISO 39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартыг орчуулгыг хянах ажлын хүрээнд</i></p> <p>ISO 39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартыг орчуулгыг хянаж, нэр томъёо ба тодорхойлолт, ойлголтыг мөрдөгдөж байгаа эрх зүйн хууль, тогтоомжтой нийцүүлж ойлгомжтой болгох зорилгоор хянаж, Замын цагдаагийн газар, АТҮТ болон ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн багш, мэргэжилтнүүдээр хянуулж, санал авсан.</p> <p>Хянасан, саналыг тусгасан ISO 39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын менежментийн тогтолцоо - Шаардлага, хэрэглэх зааврын хамт стандартын төслийг хавсаргав. Хавсралт 2.</p> <p>Саналын товчоог хавсаргав. Хавсралт 3</p>
2	<p><i>ISO 39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын сургалтын гарын авлага боловсруулах, хэвлүүлэх.</i></p> <p>ISO 39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын сургалтын гарын авлага боловсруулж, хэвлүүлэн, суралцагчдад тараасан.</p> <p>Сургалтын гарын авлагын нүүрний зургийг хавсаргав. Хавсралт 4</p>
3	<p><i>MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Модуль 1, Танилцуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулах</i></p>

	<p>MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Модуль 1, Танилцуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулж оролцогч талуудтай зөвшилцсөн. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав. Хавсралт 5.</p>
4	<p>MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Модуль 2, Сургагч багшийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сонирхогч талуудад танилцуулж, зөвшилцсөн. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав. Хавсралт 6.</p>
5	<p>MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Модуль 3. Дотоод аудитын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сонирхогч талуудад танилцуулж, зөвшилцсөн. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав. Хавсралт 7.</p>
6	<p>MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Модуль 4. Тэргүүлэх аудиторын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сонирхогч талуудад танилцуулж, зөвшилцсөн. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав. Хавсралт 8.</p>
7	<p>MNS ISO 39001: 2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын зөвлөхүүдийг бэлдэх хөтөлбөр боловсруулж, сонирхогч талуудад танилцуулж, зөвшилцсөн. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав. Хавсралт 9.</p>
8	<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба болон “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай хамтран зөвлөх, сургагч багш, дотоод аудитор, тэргүүлэх аудиторуудын сургалтад хамрагдах хүмүүсийг сонгосон. Сургалтанд хамрагдсан хүмүүсийн бүртгэлийг хавсаргав. Хавсралт 10.</p>
9	<p>MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын сургагч багш нарыг сургалтыг зохион байгуулсан. Нийт 34 хүн хамрагдаж, Зөвлөхийн гэрчилгээ авсан. Хавсралт 10-т бүртгэлтэй танилцана уу.</p> <p>Нийт 34 хүн хамрагдаж, Сургагч багшийн гэрчилгээ авсан. Хавсралт 10-т өгсөн бүртгэлтэй танилцана уу.</p>
10	<p>MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Дотоод аудитын сургалтыг зохион байгуулсан. Нийт 45 хүн хамрагдаж, Дотоод аудиторын гэрчилгээ авсан. Хавсралт 10-т өгсөн бүртгэлтэй танилцана уу.</p>

11	<p>MNS ISO 39001 : 2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Тэргүүлэх аудиторовын сургалтыг зохион байгуулах.</p> <p>Нийт 23 хүн хамрагдаж, Эхний шалгалтад 16 хүн тэнцэж Тэргүүлэх аудиторовын гэрчилгээ авсан. Хавсралт 10-т өгсөн бүртгэлтэй танилцана уу. Шалгалтанд тэнцээгүй хүмүүст давтан зааварчилгааг өгч, шалгалтыг дахин авахаар төлөвлөж байна.</p>
12	<p>MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын зөвлөхүүдийг бэлдэх</p> <p>Нийт 34 хүн хамрагдаж, Зөвлөхийн гэрчилгээ авсан. Хавсралт 10-т өгсөн бүртгэлтэй танилцана уу.</p>
13	<p>Зөвлөх үйлчилгээний тайлан боловсруулж, Зам тээврийн хөгжлийн төвийн удирдлагад танилцуулахад бэлтгэв.</p>

ТАНИЛЦСАН:




С.ДАВААНЫМ

БОЛОВСРУУЛСАН:



Л.ТУНГАЛАГ

Хавсралт 1. Ажлын төлөвлөгөө

БАТЛАВ:  С.ДАВААНЯМ
(ТӨСЛИЙН БАГИЙН АХЛАГЧ)

MNS ISO 39001:2014 “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ (ЗХАБ) УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО” НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 10-р сарын 20 -ны өдөр
хот

Улаанбаатар

ЗОРИЛГО: MNS ISO 39001:2014 “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ (ЗХАБ) УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО” НЭВТРҮҮЛЭХ

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: АТҮТ, Удирдах урлаг хөгжил ТББ

№	Хийх ажлын нэр	Хугацаа	Гарах үр дүн
	ISO 39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартыг орчуулгыг хянах	17.11.2023	Орчуулгын хяналт хийсэн стандарт бий болно
	ISO 39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын сургалтын гарын авлага боловсруулах, хэвлүүлэх.	01.12.2023	
	MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Модуль 1, Танилцуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулах	08.12.2023	Танилцуулах сургалтын хөтөлбөртэй болно
	MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо	14.12.2023	Сургагчийн багшийн хөтөлбөртэй болно

	стандартын Модуль 2, Сургагч багшийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах		
	MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Модуль 3. Дотоод аудитын сургалтын хөтөлбөрийг боловсруулах	15.12.2023	Дотоод аудитын хөтөлбөртэй болно
	MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Модуль 4. Тэргүүлэх аудиторын сургалтын хөтөлбөрийг боловсруулах	21.12.2023	Тэргүүлэх аудиторын сургалтын хөтөлбөртэй болно
	MNS ISO 39001: 2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын зөвлөхүүдийг бэлдэх хөтөлбөр боловсруулах	23.12.2023	Зөвлөх бэлтгэх хөтөлбөртэй болно
	Замын хөдөлгөөний аюулгүй байдалын үндэсний зөвлөлийн ажлын алба болон “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай хамтран зөвлөх, сургагч багш, дотоод аудитор, тэргүүлэх аудиторуудын сургалтад хамрагдах хүмүүсийг сонгоно.	01.12.2023	Сургалтад хамрагдах хүмүүсийн жагсаалт гарна
	MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын сургагч багш нарыг сургалтыг зохион байгуулах	08-10.01.2024	30+мэргэжилтнийг сургагч багш болно
	MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Дотоод аудитын сургалтыг зохион байгуулах	24-26.01.2024	40+мэргэжилтэн дотоод аудитор болно
	MNS ISO 39001 : 2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын Тэргүүлэх аудиторын сургалтыг зохион байгуулах	19-23.01.2024	20+ Тэргүүлэх аудитор болно

	MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо стандартын зөвлөхүүдийг бэлдэх	10.01-03.15.20 24	20 зөвлөхтэй болно
	ISO 39001 Стандартыг амжилттай хэрэгжүүлж байгаа 3-аас доошгүй улс орнуудын туршлагаас судалж, тайлан боловсруулах.	05.01.2024	Тайлан гарна, танилцуулна
	Зөвлөх үйлчилгээний тайлан боловсруулах, Зам тээврийн хөгжлийн төвийн удирдлагад танилцуулна	22.03.2024	Зөвлөх үйлчилгээний тайлан хүргэгдсэн байна

:
БОЛОВСРУУЛСАН:



Л.ТУНГАЛАГ

Хавсралт 2. Стандартын төсөл

ISO 39001:2012 (MNS ISO 39001:2014) стандарт. Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын менежментийн тогтолцоо - Шаардлага, хэрэглэх зааврын хамт

Road traffic safety (RTS) management systems - Requirements with guidance for use

1	Хамрах хүрээ.....	3
2	Норматив ишлэл.....	3
3	Нэр томъёо, тодорхойлолт.....	3
4	Байгууллагын төлөв байдал.....	9
4.1	Байгууллага ба түүний төлөв байдлыг ойлгох.....	9
4.2	Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох.....	9
4.3	ЗХАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох.....	10
4.4	ЗХАБ-ын менежментийн тогтолцоо.....	10
5	Манлайлал.....	10
5.1	Манлайлал ба үүрэг амлалт.....	10
5.2	Бодлого.....	11
5.3	Зохион байгууллалтын үүрэг хариуцлага, эрх мэдэл.....	11
6	Төлөвлөлт.....	11
6.1	Ерөнхий зүйл.....	11
6.2	Эрсдэл, боломжуудад авах арга хэмжээ.....	11
6.3	ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлс.....	12
6.4	ЗХАБ-ын зорилтууд, түүнд хүрэх төлөвлөлт.....	13
7	Дэмжлэг.....	14
7.1	Зохицуулалт.....	14
7.2	Нөөц.....	14
7.3	Чадамж.....	14
7.4	Мэдлэг.....	14
7.5	Мэдээлэл харилцаа.....	14
7.6	Баримтжуулсан мэдээлэл.....	15
8	Ажиллагаа.....	16
8.1	Ажиллагааны төлөвлөлт ба хяналт.....	16
8.2	Онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээ.....	16
9	Гүйцэтгэлийн үнэлгээ.....	16

9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ.....	16
9.2 Зам тээврийн осол ба зам тээврийн бусад тохиолдлын судалгаа.....	16
9.3 Дотоод аудит.....	17
9.4 Удирдлагын дүн шинжилгээ.....	17
10 Сайжруулалт.....	18
10.1 Үл тохирол ба залруулах арга хэмжээ.....	18
10.2 Байнгын сайжруулалт.....	18
А хавсралт.....	19
(мэдээллийн).....	19
Энэхүү олон улсын стандартыг хэрэглэх заавар.....	19
Хавсралт Б.....	32
(мэдээллийн).....	32
Замын хөдөлгөөнийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоотой холбоотой олон улсын хэмжээнд хийгдэж байгаа ажил.....	32

1 Хамрах хүрээ

Энэхүү олон улсын стандарт нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын (ЗХАБ) менежментийн тогтолцоонд тавих шаардлагыг тогтоож, зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, хүнд гэмтлийг бууруулах боломжийг замын хөдөлгөөний тогтолцоог бүрдүүлж байгаа байгууллагад олгоно. Энэхүү олон улсын стандартад тавигдах шаардлагад ЗХАБ-ын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, тухайн байгууллагын дагаж мөрддөг хууль эрх зүйн болон бусад хэрэгцээг тодорхойлох, ЗХАБ-ын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, тухайн байгууллагатай холбоотой ЗХАБ-тай холбоотой элемент, шалгуурын талаарх мэдээлэл, хяналт хамаарна.

Энэхүү олон улсын стандарт нь төрөл, хэмжээ, үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс үл хамааран аливаа байгууллагад хамаарна. Үүнд:

- a) ЗХАБ-ын гүйцэтгэлийг сайжруулах;
- b) ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, сайжруулах;
- c) ЗХАБ-ын бодлогод нийцэж байгааг баталгаажуулах;
- d) энэхүү олон улсын стандартад нийцэж байгааг харуулах.

Энэхүү олон улсын стандартад ЗХАБ-ын менежментийн тогтолцооны шаардлагыг тогтоох зорилгоор боловсруулсан. Энэ нь техникийн болон тээвэрлэлтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын шаардлага (Жишээлбэл: зам, замын тэмдэг, гэрэл дохио, автомашин, трамвай, ачаа тээвэр, зорчигч тээвэр, аврах болон яаралтай тусламжийн үйлчилгээ)-ын талаар тодорхой зааж өгөх зорилгогүй юм.

Энэхүү олон улсын стандарт нь ЗХАБ-ын менежментийн тогтолцооны бүтцийн нэгдмэл байдал эсвэл баримт бичгийн нэгдмэл байдлыг илэрхийлэхгүй. ЗХАБ нь хамтын хариуцлага юм.

Энэхүү олон улсын стандарт нь замын хөдөлгөөнд оролцогчдын хууль тогтоомж биелүүлэх, биеэ авч явах үүрэг хариуцлагыг үгүйсгээгүй. Харин замын хөдөлгөөнд оролцогчид хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг байгууллагаас урамшуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү олон улсын стандартын бүх шаардлага нь ерөнхий шинж чанартай байна.

Байгууллагын шинж чанараас шалтгаалан энэхүү олон улсын стандартын шаардлагыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээнд дагаж мөрдөх боломжгүй тохиолдолд уг шаардлагыг хассан гэж үзэж хассан шалтгааныг баримтжуулахыг санал болгоно.

Үл хамаарах зүйл нь тухайн байгууллагын ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, сайжруулах чадварт нөлөөлөхгүй тохиолдолд энэхүү олон улсын стандартад нийцсэн тухай нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрнө.

2 Норматив ишлэл

Ямар нэгэн норматив тайлбар байхгүй болно.

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичгийн зорилготой холбоотой дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1 аудит

бодит нотолгоо (3.4)-г олж, энэ нь аудитын шалгуур (3.3)-тай хэрхэн нийцэж буйг бодитойгоор тогтоох байнгын, бие даасан, баримтжуулсан үйл явц (3.27)

ТАЙЛБАР 1: Дотоод аудит (нэг дахь талын) буюу хөндлөнгийн аудит (хоёрдогч болон гуравдагч талын) хамтарсан аудит (хоёр буюу түүнээс дээш) байж болно

ТАЙЛБАР 2: "Аудитын нотолгоо", "Аудитын шалгуур"-ыг ISO 19011-д тайлбарласан

3.2 аудитор

Аудит (3.1) хийх хувийн шинж чанар, чадамж (3.7)-тай хүн

ТАЙЛБАР 1: Аудиторын хувийн шинж чанаруудыг ISO 19011 стандартад тодорхойлсон.

3.3 аудитын шалгуур

Аудитын нотолгоо (3.4)-г харьцуулах эшлэл болгон ашигласан бодлого, журам эсвэл шаардлагын багц

3.4 аудитын нотолгоо

аудитын шалгуур (3.3)-т хамаарах, шалгах боломжтой бүртгэл, баримтын мэдэгдэл эсвэл бусад мэдээлэл

3.5 боломжтой хамгийн сайн мэдээлэл

ашигласан өгөгдөл, загварчлалын аливаа мэдэгдэж байгаа хязгаарлалт, эсвэл мэргэжилтнүүдийн хооронд санал зөрөлдөөн гарах боломжийг харгалзан үзсэн байгууллагад байгаа мэдээлэл

ТАЙЛБАР 1: Үүнд нотолгоо, шинжлэх ухааны аюулгүй байдлын судалгаа, туршлага, санал хүсэлт, ажиглалт, урьдчилсан таамаглал, шинжээчийн дүгнэлт.

ТАЙЛБАР 2: Байгууллагын нөөц боломжоос хамаарна.

3.6 амлалт

Менежментийн тогтолцоо (3.16)-нд хамаарах ажил, хичээл зүтгэлийн түвшин

3.7 чадамж

Хүссэн үр дүнд хүрэхийн тулд мэдлэг, ур чадвараа ашиглах чадвар

3.8 тохирол

шаардлага биелэх

3.9 байнгын сайжруулалт

гүйцэтгэл (3.23)-ийг сайжруулах давтагдаг үйл ажиллагаа

3.10 залруулга

илэрсэн үл тохирол (3.19)-ыг арилгах арга хэмжээ

3.11 залруулах арга хэмжээ

үл тохирол (3.19)-ын шалтгааныг арилгах болон дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээ

3.12 нас баралт

зам тээврийн осол (3.33)-ын шууд үр дүнд хүний амь нас хохирсон.

ТАЙЛБАР 1: Зам тээврийн ослын улмаас 30 хоногийн дотор амиа хорлохыг эс тооцвол зам тээврийн ослын шууд үр дүнд хүн нас барахыг ойлгодог олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байдаг. Өөр өөр улс оронд бусад тодорхойлолт байж болно

3.13 баримтжуулсан мэдээлэл

байгууллагын хяналтанд байлгаж, хадгалж байвал зохих мэдээлэл болон түүнийг хадгалж буй зөөгч

ТАЙЛБАР 1: Баримтжуулсан мэдээлэл нь ямар ч хэлбэртэй, зөөгчтэй мөн аль ч эх сурвалжаас гаралтай байж болно.

ТАЙЛБАР 2: Баримтжуулсан мэдээлэлд дараах зүйлсийг багтааж болно:

- менежментийн тогтолцоо (3.16), түүнд хамаарах үйл явцууд (3.27);
- байгууллагыг ажиллуулахын тулд бий болсон мэдээлэл (баримтжуулалт);
- хүрсэн үр дүнгүүдийн нотолгоо (бүртгэлүүд).

3.14 үр ашиг

төлөвлөсөн ажлууд хэр зэрэг хэрэгжиж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн

3.15 сонирхогч тал

шийдвэр эсвэл үйл ажиллагаанд нөлөөлж болох, нөлөөнд автаж болох эсвэл өөрийгөө нөлөөнд автана гэж төсөөлж буй оролцогч хүн эсвэл байгууллага

ТАЙЛБАР 1: Сонирхогч талд ажилтнууд, гэрээгээр ажиллагсад, нийлүүлэгч, үйлчлүүлэгч бусад нөлөө бүхий гуравдагч талууд хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

3.16 менежментийн тогтолцоо

Бодлого (3.24) ба зорилт (3.20)-уудыг тодорхойлох, харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлтэй, байгууллага (3.21)-ын элементүүдийн багц ба тэдгээр зорилтуудыг хангах үйл явцууд (3.27)

ТАЙЛБАР 1: Менежментийн тогтолцоо нь нэг болон хэд хэдэн салбарыг хамаарч болно.

ТАЙЛБАР 2: Системийн элементүүдэд байгууллагын бүтэц, үүрэг, хариуцлага, төлөвлөлт, үйл ажиллагаа гэх мэт хамаарна.

ТАЙЛБАР 3: Менежментийн тогтолцооны хамрах хүрээ нь байгууллагыг бүхэлд нь, байгууллагын тусгай ба тодорхой чиг үүргийг, байгууллагын тусгай ба тодорхой хэсгийг эсвэл бүлэг байгууллагуудыг дамнасан нэг буюу хэд хэдэн чиг үүргийг хамарч болно.

3.17 хэмжилт

утга тодорхойлох үйл явц (3.27)

3.18 мониторинг

тогтолцоо, үйл явц (3.27) эсвэл үйл ажиллагааны байдлыг тодорхойлох

Тайлбар 1: Байдлыг тодорхойлохдоо шалгах, хяналт тавих эсвэл анхааралтай ажиглах хэрэгцээ гарч болно.

3.19 үл тохирол

шаардлага (3.28) үл биелэгдэх байдал

3.20 зорилт

хүрэх үр дүн

ТАЙЛБАР 1: Зорилт нь стратегийн, тактикийн, эсвэл ажиллагааны гэж байдаг.

ТАЙЛБАР 2: Зорилтууд нь өөр өөр асуудалд (санхүүгийн, эрүүл мэнд ба аюулгүй байдлын, байгаль орчны зорилтууд зэрэг) хамааралтай байдаг ба өөр өөр түвшинд [стратегийн, байгууллагын хэмжээний, төслийн, бүтээгдэхүүний, үйл явцын (3.27) гэх мэт] хэрэглэж болдог.

ТАЙЛБАР 3: Зорилтыг өөр хэлбэрээр илэрхийлж болно, жишээлбэл, төлөвлөсөн үр дүн, зорилго, үйл ажиллагааны шалгуур, ЗХАБ-ын зорилт болгон эсвэл ижил утгатай бусад үгсийг (жишээлбэл, зорилго, чиглэл) ашиглах замаар.

ТАЙЛБАР 4: ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд ЗХАБ-ын зорилтыг байгууллага ЗХАБ-ын бодлогын хүрээнд тодорхой үр дүнд хүрэх гэсэн утгаар оруулсан.

3.21 байгууллага

Зорилго/зорилт (3.20)-доо хүрэх үүрэг хариуцлага, эрх мэдэл, харилцаа, чиг үүрэгтэй хүн эсвэл бүлэг хүмүүс

Тайлбар 1: Байгууллагын тухай ойлголтод бизнес эрхлэгч, компани, корпораци, пүүс, хувийн хэвшил, эрх бүхий хүн, түншлэгч, институт, нэгдэл, хэсэг мөн түүнчлэн улсын болон хувийн гэж хязгаарлахгүй оруулан ойлгоно.

3.22 аутсорсинг (үйл үг)

байгууллагын чиг үүрэг, үйл явц (3.27)-ын нэг хэсгийг гадны байгууллага (3.21) гүйцэтгэх зохицуулалт хийх

Тайлбар 1: Хөндлөнгийн байгууллага нь менежментийн тогтолцоо (3.16)-ны хамрах хүрээнд орохгүй ч аутсорсингийн үйл ажиллагаа эсвэл үйл явц нь зорилтын хамрах хүрээнд багтана.

3.23 гүйцэтгэл

хэмжиж болохуйц үр дүн

ТАЙЛБАР 1: Гүйцэтгэл нь тоон эсвэл чанарын үр дүнтэй холбоотой байдаг.

ТАЙЛБАР 2: Гүйцэтгэл нь үйл ажиллагаа, үйл явц (3.27), бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтолцоо эсвэл байгууллагын менежментийн тогтолцоо (3.21)-той хамаатай байж болно.

3.24 бодлого

дээд удирдлага (3.45)-аас албан ёсоор илэрхийлсэн байгууллага (3.21)-ын чиглэл ба зорилт

1-Р ТАЙЛБАР: ЗХАБ-ын бодлогод ЗХАБ-ын зорилтот үр дүн (3.43), үйл ажиллагааны хамрах хүрээ, ЗХАБ-ын зорилт (3.20) хамаарна.

3.25 сэргийлэх арга хэмжээ

болзошгүй үл тохирол (3.19)-ын шалтгааныг арилгах арга хэмжээ

3.26 журам

үйл ажиллагаа эсвэл үйл явц (3.27)-ыг явуулах тогтоосон арга зам

3.27 үйл явц

Оролтыг гаралт болгон хувиргах харилцан уялдаатай, харилцан үйлчлэлийн багц

3.28 шаардлага

тогтоосон, нийтээр зөвшөөрсөн, эсвэл заавал биелүүлэх хэрэгцээ ба хүлээлт

ТАЙЛБАР 1: “Нийтээр зөвшөөрсөн” гэж хэрэгцээ ба хүлээлт нь байгууллага (3.1) ба сонирхогч тал (3.2)-уудын хувьд хэлэлцэн зөвшөөрснөөр заншил эсвэл нийтлэг туршлага болж тогтохыг хэлнэ.

ТАЙЛБАР 2: Тусгай шаардлага гэдэг нь тодорхойлогдсон зүйл байх бөгөөд жишээ нь баримтжуулсан мэдээлэл

3.29 эрсдэл

тодорхой бус байдлын үр нөлөө

ТАЙЛБАР 1: Үр нөлөө бол хүлээлтийн хазайлт-ээрэг эсвэл сөрөг.

ТАЙЛБАР 2: Тодорхой бус байдал бол үйл явдал, түүний үр дагавар эсвэл боломжийн талаарх ойлголт эсвэл мэдлэгтэй холбоотой мэдээллийн хэсэгчлэсэн ч гэсэн хомсдолын байдал юм.

ТАЙЛБАР 3: Эрсдэл нь болзошгүй үйл явдлууд ба үр дагаврууд эсвэл нийлбэрийг иш татсанаар ихэвчлэн тодорхойлогдоно (ISO Guide 73:2009, 3.5.1.3-д тодорхойлсон).

Энэхүү олон улсын стандартад ЗХАБ-тай холбоотой эрсдэл гэдэг нь осол (үйл явдал) болон үхэл, ноцтой гэмтэл (үр дагавар) зэргийг хэлнэ.

ТАЙЛБАР 4: Эрсдэл нь үйл явдлын (нөхцөл байдлын өөрчлөлтийг багтаан) үр дагавар ба боломжуудын илрэлийн нийлбэрээр ихэвчлэн илэрхийлэгддэг. (ISO Guide 73:2009, 3.6.1.1-д тодорхойлсон).

3.30 зам

зэргэлдээх талбайг оруулаад тээврийн хэрэгсэл болон хүмүүс зорчиход зориулагдсан зурвас газар

ТАЙЛБАР 1: Төмөр замын гарам эсхүл трамвайн замын хэсэг хамаарна.

3.31 авто замын сүлжээ

тухайн бүс нутаг дэвсгэр дэх авто зам (3.30)-ын сүлжээ

3.32 замын хөдөлгөөн

хүн ба тээврийн хэрэгслийн авто зам (3.30)-ын ашиглалт

3.33 зам тээврийн осол

зам (3.30) дээр мөргөлдөх буюу бусад хэлбэрийн ослын улмаас нас баралт (3.12)-ад хүргэх, аливаа гэмтэл эсхүл хохирол учрах

ТАЙЛБАР 1: Энэхүү олон улсын стандартаар байгууллага (3.21)-ын зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт болон хүнд гэмтэлээс сэргийлэх (3.44) урт хугацааны болон завсрын хугацааны зорилтот сайжруулалтанд гол анхаарлаа хандуулдаг;

3.34 зам тээврийн аюултай тохиолдол

Замын хөдөлгөөний тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг (3.36) эсвэл гадаад хүчин зүйлийн саатлаас үүссэн нөхцөл байдал

ТАЙЛБАР 1: Зам тээврийн осол (3.33) болон осол гарахад дөхсөн тохиолдлууд орно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.

ТАЙЛБАР 2: Саатал үүсгэж болзошгүй бүрэлдэхүүн хэсгүүдийн жишээнд замын хөдөлгөөнд оролцогчид (3.37), тээврийн хэрэгсэл, авто зам (3.30) эсвэл урьдчилан таамаглаагүй аянга цахих, мал, амьтан гэх мэт гадны хүчин зүйлс орно.

3.35 замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)

Зам тээврийн осол (3.33) болон бусад замын хөдөлгөөний аюултай тохиолдол (3.34)-той холбоотой нөхцөл, хүчин зүйлүүд нь замын хөдөлгөөнд оролцогчид (3.37)-ийн үхэл, хүнд гэмтэлд үзүүлэх нөлөөлөл, эсвэл нөлөөлөх боломжтой

3.36 замын хөдөлгөөний тогтолцоо

зам (3.30), тээврийн хэрэгсэл, яаралтай тусламжийн систем ба замын хэрэглэгчид (3.37), тэдгээрийн харилцан үйлчлэл

3.37 замын хөдөлгөөнд оролцогч

зам дээр байгаа бүх хүн (3.30)

3.38 ЗХАБ-ын хангалтгүй байдал

Замын хөдөлгөөнд оролцогчдын (3.37) амь нас, хүнд гэмтэл учруулах, эсхүл хүргэж болзошгүй зам тээврийн осол (3.33) болон зам тээврийн осол (3.33) үүсгэдэг замын хөдөлгөөний тогтолцоо (3.36)-тай холбоотой нөхцөл, хүчин зүйлсийн төлөв байдал

3.39 ЗХАБ-ын залруулах арга хэмжээ

зам тээврийн осол (3.33)-ын шалтгааныг арилгах арга хэмжээ

3.40 ЗХАБ-ын гүйцэтгэл

байгууллага (3.21)-ын ЗХАБ-д оруулсан хувь нэмрийн менежментийн хэмжигдэхүйц үр дүн (3.35)

Тайлбар 1: ЗХАБ-ын менежментийн тогтолцооны хүрээнд үр дүнг тухайн байгууллагынхтай харьцуулж хэмжиж болно

Байгууллага (3.21)-ын ЗХАБ-ын бодлого (3.24), ЗХАБ-ын зорилтууд (3.20), ЗХАБ-ын зорилтот үр дүн (3.43) болон ЗХАБ-ын гүйцэтгэлийн бусад шаардлага.

3.41 ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйл

Байгууллага (3.21)-ын ЗХАБ (3.35)-д нөлөөлөх байдлыг тодорхойлох боломжийг олгодог болон ЗХАБ-д нөлөөлж болох хэмжигдэхүйц хүчин зүйл, бүрэлдэхүүн ба шалгуур

Тайлбар 1: Энэ нь байгууллага (3.21)-д, үүнд гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нар багтсан, ЗХАБ-ын гүйцэтгэлийн өөрчлөлтийг тодорхойлох боломжийг олгодог (3.23). Энэ нь тухайн байгууллагын цаг хугацааны туршид гүйцэтгэлийг мөшгөхөд ашиглах боломжтой үйл ажиллагааны аливаа нэг хэмжигдэхүйц бүрэлдэхүүн юм.

3.42 ЗХАБ-ын сэргийлэх арга хэмжээ

зам тээврийн осол (3.33)-ын эрсдэл (3.29)-ийг бууруулах, арилгах арга хэмжээ

3.43 ЗХАБ-ын зорилтот үр дүн

Байгууллага (3.21) өөрөө эсхүл сонирхогч талуудын хамт хэрэгжүүлэх бодлого (3.24) болон ЗХАБ-ын зорилтууд (3.20)-д нийцүүлэн (3.23) хүрэх ёстой нарийвчилсан гүйцэтгэл (3.23)

3.44 хүнд гэмтэл

зам тээврийн осол (3.33)-ын улмаас хүний эрүүл мэндэд удаан хугацаанд нөлөөлөх эсхүл хүний бие махбодийн аливаа үйл ажиллагаанд хөнгөн бус хохирол учруулах гэмтэл

3.45 дээд удирдлага

байгууллагыг (3.21) хамгийн дээд шатанд удирдан чиглүүлж ба хянаж байдаг хувь хүн эсвэл бүлэг хүмүүс

Тайлбар 1: Дээд удирдлага нь байгууллагын хэмжээнд эрх мэдлийг даалгах болон нөөцөөр хангах эрх мэдэлтэй.

Тайлбар 2: Менежментийн тогтолцоо (3.16) нь байгууллагын зөвхөн нэг хэсгийг хамарч байгаа тохиолдолд дээд удирдлага гэдэгт байгууллагын тухайн хэсгийг удирдан чиглүүлж, хянадаг хүнийг ойлгоно.

4 Байгууллагын төлөв байдал

4.1 Байгууллага ба түүний төлөв байдлыг ойлгох

Байгууллага ЗХАБ-ын менежментийн тогтолцооны хүрээнд зорьсон үр дүнд хүрэх, зорилтоо хэрэгжүүлэхэд хамааралтай гадаад, дотоод асуудлуудыг тодорхойлсон байна.

Байгууллага нь:

- замын хөдөлгөөний тогтолцоонд гүйцэтгэх үүргийг тодорхойлох;
- ЗХАБ-д нөлөөлж болох үйл явц, холбогдох үйл ажиллагаа, байгууллагын чиг үүргийг тодорхойлох;

- эдгээр үйл явц, үйл ажиллагаа, чиг үүргийн дараалал, харилцан үйлчлэлийг тодорхойлох.

4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох

Байгууллага нь дараахь зүйлийг тодорхойлсон байна:

- ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд хамаарах сонирхогч талууд;
- эдгээр сонирхогч талуудын шаардлага;
- байгууллагын тогтоосон ЗХАБ-тай холбоотой хууль, эрх зүйн болон бусад шаардлага.

4.3 ЗХАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох

Байгууллага ЗХАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээг хэрэглэх зааг хязгаар, боломжид тохируулан тодорхойлно.

Хамрах хүрээг тодорхойлохдоо байгууллага дараах зүйлийг анхаарна:

- 4.1-д заасан гадаад болон дотоод асуудлууд;
- 4.2-т заасан сонирхогч талуудын шаардлага;
- 4.2-т заасан шаардлага, 6-р зүйлд заасан төлөвлөлтийн шаардлага.

Байгууллага ЗХАБ-ын менежментийн тогтолцооны төлөвлөсөн үр дүн, зам тээврийн ослын улмаас нас барах, хүнд бэртэх гэмтлийн тоог бууруулж, эцэст нь арилгахад нөлөөлж чадна гэдгийг тусгана.

Хамрах хүрээг баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр бэлэн байлгана.

4.4 ЗХАБ-ын менежментийн тогтолцоо

Байгууллага нь энэхүү олон улсын стандартын шаардлагад нийцсэн үйл явцууд болон тэдгээрийн харилцан үйлчлэл бүхий ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж, хадгалж, байнга сайжруулна.

5 Манлайлал

5.1 Манлайлал ба үүрэг амлалт

Дээд удирдлага ЗХАБ-ын менежментийн тогтолцооны талаарх манлайлал ба үүрэг амлалтыг дараах байдлаар харуулна:

- байгууллагын стратегийн чиглэлтэй уялдсан ЗХАБ-ын бодлого ба холбогдох ЗХАБ-ын зорилтуудыг тогтоосон байхыг хариуцах;
- ЗХАБ-ын менежментийн тогтолцооны шаардлагыг байгууллагын бизнес үйл явцад нэгтгэсэн байх нөхцлийг хангах;
- ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд шаардлагатай нөөцийг бэлэн байлгах;
- Зам тээврийн ослын улмаас амь насаа алдах, хүнд бэртсэн гэмтлийг арилгах урт хугацааны ЗХАБ-ын зорилт хэрэгжүүлэх, завсрын хугацаанд хүрэх ЗХАБ-ын зорилтот үр дүнг шийдвэрлэх;

- аюулгүй замын хөдөлгөөнд оруулах хувь нэмрийг хөгжүүлэхэд сонирхогч талуудтай хамтран ажиллах;
- ЗХАБ-ын үр дүнд хүрэх үйл явц, байгууллагын бүх түвшний оролцоог хангах;
- ЗХАБ-ын менежментийн тогтолцооны зорилтод үр дүнд хүрэх мэдээлэлд тулгуурлан стратегийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны тусгай чиглэлүүдийг эрэмбэлэх
- ЗХАБ-ын үр дүнтэй менежментийн ач холбогдлыг мэдээлэх, ЗХАБ-ын менежментийн тогтолцоотой нийцүүлэх;
- ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, тасралтгүй сайжруулах нөөцөөр хангах;
- ЗХАБ-ын үр дүнд анхаарлаа төвлөрүүлснээр ЗХАБ-ын менежментийн тогтолцоо нь төлөвлөсөн үр дүнд хүрэхийг хангах;
- зорилтот үр дүнд хүрэхийн тулд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн ач холбогдлыг баталгаажуулах
- ЗХАБ-ын менежментийн тогтолцоог байгууллагын бүх холбогдох ажилтнуудад мэдээлэх;
- ЗХАБ-ын менежментийн тогтолцоог үр дүнтэй болгоход хувь нэмрээ оруулахад хүмүүсийг чиглүүлэх, сурталчлах;
- байнгын сайжруулалт;
- тухайн салбартаа хамаатай манлайллыг харуулахын тулд бусад холбогдох удирдлагын үүргийг хариуцлагыг дэмжих.

ТАЙЛБАР: Энэхүү олон улсын стандартад “бизнес” гэдэг үгийг өргөн утгаар хэрэглэх ба олон нийтийн, хувийн, ашгийн болон ашгийн бус байхаас үл хамааран тухайн байгууллагын оршин тогтнох үндсэн зорилго бүхий үйл ажиллагаанд хамааралтай байна.

5.2 Бодлого

Дээд удирдлага дараах агуулга бүхий ЗХАБ-ын бодлогыг бий болгоно:

- a) байгууллагын зорилгод тохирсон байх;
- b) ЗХАБ-ын зорилго болон ЗХАБ-ын зорилтуудыг тогтоох тогтоцыг хангасан;
- c) холбогдох шаардлагыг хангах амлалтыг багтаасан;
- d) ЗХАБ-ын менежментийн тогтолцоог байнга сайжруулах амлалтыг тусгасан.

Бодлого нь:

- баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр бэлэн байх;
- байгууллага дотроо мэдээлэх;
- шаардлагатай бол сонирхогч талуудад нээлттэй байх.

5.3 Зохион байгууллалтын үүрэг хариуцлага, эрх мэдэл

Дээд удирдлага байгууллагын хүрээнд тодорхойлсон холбогдох үүрэг хариуцлага, эрх мэдлийг хуваарилж, байгууллагын хэмжээнд мэдээлж ойлгуулна.

Дээд удирдлага дараахь хариуцлага, эрх мэдлийг хуваарилна:

- a) ЗХАБ-ын менежментийн тогтолцоо нь энэхүү олон улсын стандартын шаардлагад тохирсон байх;

б) ЗХАБ-ын менежментийн тогтолцооны гүйцэтгэлийн талаар сайжруулах зөвлөмжийн хамт дээд удирдлагад тайлагнах.

6 Төлөвлөлт

6.1 Ерөнхий зүйл

Байгууллага нь одоогийн ЗХАБ-ын гүйцэтгэлийг хянаж, эрсдэлийг тодорхойлох үйл явцыг хэрэгжүүлж боломжийг ашиглах, ЗХАБ-ын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, цаг хугацааны явцад юунд хүрч болох талаар дүн шинжилгээ хийж, зохих ЗХАБ-ын зорилго, ЗХАБ-ын зорилтууд, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргана.

ЗХАБ-ын одоогийн гүйцэтгэлийг хянахдаа тухайн байгууллагын төлөв байдлыг харгалзан үзэх (4-р зүйлийг үзнэ үү) ба манлайлал (5-р зүйлийг үзнэ үү), үйл явц, холбогдох үйл ажиллагаа болон байгууллагын ЗХАБ-д нөлөөлж болох чиг үүрэгтэй холбогдох одоогийн ЗХАБ-ын гүйцэтгэлийг тоон үзүүлэлтээр илэрхийлж, боломжтой бол, ЗХАБ-ын гүйцэтгэлийн дагуу ирээдүйн болзошгүй нөлөөллийн хүчин зүйлүүдийн үнэлгээг хийсэн байна.

6.2 Эрсдэл, боломжуудад авах арга хэмжээ

Байгууллага ЗХАБ-ын менежментийн тогтолцоог төлөвлөхдөө 4.1-д заасан асуудлууд, 4.2-т өгсөн шаардлагыг үндэслэн:

- ЗХАБ-ын менежментийн тогтолцоо төлөвлөсөн үр дүнд хүрнэ гэсэн баталгаа гаргах;
- хүсээгүй үр дүнгээс сэргийлэх буюу бууруулах;
- байнгын сайжруулалт хийх.

Байгууллага:

- а) эдгээр эрсдэл, боломжуудыг арилгах арга хэмжээ;
- б) яаж гэдгийг төлөвлөнө.

Эдгээр арга хэмжээг ЗХАБ-ын менежментийн тогтолцооны үйл явцуудыг нэгтгэх, хэрэгжүүлэх, үйлдэлийн үр нөлөөг үнэлэнэ.

6.3 ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлс

Байгууллага нь тухайн байгууллагын төлөв байдал (4-р зүйлийг үзнэ үү), тодорхойлсон эрсдэл, боломжоос хамааран эрсдэлд өртөх хүчин зүйл, аюулгүй байдлын хүчин зүйл, аюулгүй байдлын үр дүнгийн завсрын хүчин зүйлийн жагсаалтаас ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлийг ашиглахаар тодорхойлно.

а) Эрсдэлд өртөх хүчин зүйлүүд:

Байгууллагын нөлөөлөлд өртсөн, нөлөөлсөн эсэхээс үл хамааран тээврийн хэрэгсэл, замын хэрэглэгчийн төрлийг оролцуулан туулсан зай, замын хөдөлгөөний хэмжээ; байгууллагаас үзүүлж буй бүтээгдэхүүн ба/эсвэл үйлчилгээний хэмжээ.

б) Аюулгүй байдлын эцсийн үр дүнгийн хүчин зүйлүүд, жишээлбэл нас барсан болон хүнд бэртсэн хүмүүсийн тоо.

с) Аюулгүй байдлын үр дүнгийн завсрын хүчин зүйлүүд: эдгээр аюулгүй байдлын үр дүнгийн хүчин зүйлүүд нь замын сүлжээ, түүний доторх бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй төлөвлөлт, дизайн, ашиглалт, тэдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэглэгчдийн нэвтрэх, гарах нөхцөл, зам тээврийн ослын хохирогчдыг сэргээх, нөхөн сэргээх зэрэгтэй холбоотой байна:

- замын зураг төсөл, аюулгүй хурд, ялангуяа тусгаарлалтыг харгалзан үзэх (ирж буй хөдөлгөөн ба эмзэг зам хэрэглэгчид), хажуугийн талбай ба уулзварын дизайн;
- тээврийн хэрэгслийн төрөл, хэрэглэгч, ачааны төрөл, тоног төхөөрөмжөөс хамааран тохирох зам ашиглах;
- хувийн хамгаалалтын хэрэгслийг ашиглах, ялангуяа суудлын бүс, хүүхдийн суудал, унадаг дугуйны дуулга гэх мэт
- мотоциклийн дуулга, харагдах, харагдах хэрэгсэл;
- тээврийн хэрэгслийн төрөл, замын хөдөлгөөн, цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан аюулгүй жолоодох хурдыг ашиглах;
- жолоочийн биеийн тамир, ялангуяа ядаргаа, анхаарал сарниулах, архи, мансууруулах бодисын хэрэглээг харгалзан үзэх;
- аюулгүй аяллын төлөвлөлт, үүнд аялах хэрэгцээ, аяллын хэмжээ, хэлбэр зэргийг харгалзан үзэх
- зам, тээврийн хэрэгсэл, жолоочийн сонголт;
- тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ялангуяа зорчигчдын хамгаалалт, бусад замын хөдөлгөөнд оролцогчдын хамгаалалт (эмзэг болон тээврийн хэрэгслийн бусад зорчигчид), зам тээврийн ослоос зайлсхийх, ослыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл
- ачааны даац, тээврийн хэрэгслийн доторх ачааг бэхлэх;
- унах, жолоодох тээврийн хэрэгслийн ангиллын дагуу унах/жолоодох зохих зөвшөөрөл;
- замын сүлжээнээс тохиромжгүй тээврийн хэрэгсэл унасан/ жолоодсон хүнийг зайлуулах;
- ослын дараах хариу арга хэмжээ, анхны тусламж, яаралтай тусламжийн бэлэн байдал, ослын дараах сэргээн босголт, нөхөн сэргээлт.

Дээр дурдсан ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлс хангалтгүй байгаа тохиолдолд байгууллага нь ЗХАБ-ын гүйцэтгэлийн нэмэлт хүчин зүйлсийг боловсруулна. Холбогдох зам тээврийн ослыг судалж, ЗХАБ-ын зөрчлийг илрүүлж ЗХАБ-ын гүйцэтгэлийн нэмэлт хүчин зүйлсийг боловсруулж болно.

ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйл дээр үндэслэн байгууллага нь ЗХАБ-ын зорилго болон ЗХАБ-ын зорилтуудыг тодорхойлох, хянах, хэмжихийн тулд элементүүд болон зохих шалгууруудыг нарийвчлан зааж өгөх ёстой. Байгууллага энэ мэдээллийг баримтжуулж, шинэчилсэн байх ёстой.

ЖИШЭЭ Суудлын бүсний хэрэглээ нь ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйл болох "хувийн хамгаалалтын тоног төхөөрөмжийн ашиглалт"-тай холбоотой элемент ба шалгуурыг хоёуланг нь илэрхийлдэг. "Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал" ЗХАБ-ын

гүйцэтгэлийн хүчин зүйлийн хувьд хэрэглэгчийн аюулгүй байдлын зэрэглэл нь тухайн элемент, үнэлгээний түвшин нь шалгуур үзүүлэлтийг илэрхийлдэг.

ТАЙЛБАР: Төрөл бүрийн байгууллагуудад ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлсийг ашиглах зааврыг А.11-д өгсөн болно.

6.4 ЗХАБ-ын зорилтууд, түүнд хүрэх төлөвлөлт

Байгууллага нь холбогдох чиг үүрэг, түвшинд ЗХАБ-ын зорилтуудыг тогтооно.

ЗХАБ-ын зорилтууд:

- ЗХАБ-ын бодлоготой уялдсан;
- хэмжигдэхүйц (боломжтой бол);
- холбогдох шаардлагыг авч үзсэн;
- Хянагддаг;
- Мэдээлэгдсэн;
- Шаардлагтай тохиолдолд шинэчлэгддэг байна.

Байгууллага нь ЗХАБ-ын зорилтот үр дүн болон ЗХАБ-ын зорилтуудын талаар баримтжуулсан мэдээллийг хадгална.

Байгууллага нь ЗХАБ-ын зорилтууд болон зорилтот үр дүнг тодорхойлж, хянахдаа 6.2-т эрсдэл, боломжуудыг, 6.3-т заасан ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлийг, 6.3-т заасан элемент, шалгуурыг харгалзан үзэхийн зэрэгцээ удирдлагын чадавхийг харгалзан үзнэ. Мөн технологийн сонголт, санхүү, үйл ажиллагаа, бизнесийн шаардлага, сонирхогч талуудын санал бодлыг харгалзан үзнэ.

Байгууллага ЗХАБ-ын зорилтууд болон зорилтот үр дүнд хэрхэн хүрэхээ төлөвлөхдөө:

- юу хийсэн байх;
- ямар нөөц шаардагдлагатай болох;
- хэн хариуцаж ажиллах;
- хэзээ хийж дуусах;
- үр дүнг хэрхэн үнэлэх тухай тодорхойлно.

Үйл ажиллагааны төлөвлөгөөг баримтжуулж, шаардлагатай бол хянана.

ТАЙЛБАР 1 А.6.3-т ЗХАБ-ын зорилтот шатлалын жишээг харуулав.

ТАЙЛБАР 2. ЗХАБ-ын аливаа зорилго, ЗХАБ-ын зорилтын хэмжилтийн төрлийг ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйл, 6.3-т заасан элемент, шалгуур, түүнчлэн байгууллагын үр дүнд үндэслэн тодорхойлж болно.

7 Дэмжлэг

7.1 Зохицуулалт

Байгууллага нь холбогдох түвшин, чиг үүрэг (үүнд ажилчдын оролцоо, ерөнхийдөө хамаарна) болон сонирхогч талуудын ЗХАБ-д хамаарах үйл ажиллагаанаас бодит ашиг тусыг хүртэх талаар зохицуулалт хийнэ. Энэ үүднээс дотоод болон гаднаас тэдгээрийн ЗХАБ-ын зорилт(ууд)-ыг хангах, зорилтот үр дүнд хүрэхэд зориулсан үйл ажиллагаанд зохих зөвлөгөө өгч, зохицуулалт хийх нөхцлийг хангана.

7.2 Нөөц

Байгууллага нь ЗХАБ-ын тогтоосон зорилт(ууд), зоритот үр дүнд хүрэхийн тулд ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, тасралтгүй сайжруулахад шаардагдах нөөц болон хуваарилах хүрээг тодорхойлж, хангана.

ТАЙЛБАР: Нөөцөд хүний нөөц, мэргэшлийн ур чадвар, зохион байгууллагын дэд бүтэц, технологи, санхүүгийн нөөц орно.

7.3 Чадамж

Байгууллага нь дараах нөхцлийг бүрдүүлнэ:

- байгууллагын хяналт дор ЗХАБ-ын гүйцэтгэлд нөлөөлөх ажил эрхэлж буй хүмүүст шаардлагатай чадамжийг тодорхойлох;
- эдгээр хүмүүсийг зохих боловсрол, сургалт, туршлага дээр үндэслэн чадамжтай байх нөхцлийг бүрдүүлэх;
- боломжтой бол шаардлагатай чадамжтай болгох арга хэмжээ авах, түүний үр нөлөөг үнэлэх;
- чадамжийг нотлох зохих баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

ТАЙЛБАР: Ажиллаж байгаа хүмүүсийг сургах, тэднийг чиглүүлэх, сэлгэн томилох, эсхүл чадамжтай хүнийг ажилд авах, гэрээлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэглэх боломжтой.

7.4 Мэдлэг

Байгууллагын хяналтанд ажил хийж байгаа, ажил гүйцэтгэх явцад ЗХАБ-ын нөлөөлөлд өртсөн эсвэл нөлөөлж буй хүмүүс дараахь зүйлийг мэддэг байна:

- ЗХАБ-ын бодлого;
- түүний ЗХАБ-ын менежментийн тогтолцооны үр нөлөөтэй байлгахад оруулах хувь нэмэр, үүнд сайжруулалт хийсэн ЗХАБ-ын гүйцэтгэлийн ашиг тус хамаарна;
- ЗХАБ-ын менежментийн тогтолцооны шаардлагыг хангаагүйгээс гарах үр дагавар;
- байгууллагад тохиолдож байсан холбогдох томоохон зам тээврийн ослын талаарх мэдээлэл ба сургамж.

7.5 Мэдээлэл харилцаа

Байгууллага нь ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд дотоод болон гадаад мэдээлэл харилцааны хэрэгцээг тодорхойлсон байна, үүнд:

- юу мэдээлэх;
- хэзээ мэдээлэх;
- хэнд мэдээлэхийг авч үзнэ.

Байгууллага нь өөрийн болон сонирхогч талуудын янз бүрийн түвшин, чиг үүргийн хүрээн дэх мэдээлэл харилцааны үйл явцыг бий болгож, хэрэгжүүлж, хадгална.

Байгууллага нь ЗХАБ-ын урт хугацаан дахь үр дүн, түүнд хүрэх арга хэрэгсэлд төвлөрөх хэрэгцээг дотоод болон гадаад сонирхогч талуудыг, хэрэгтэй гэж үзвэл, ойлгуулах, тэднийг дэмжих замаар ЗХАБ-ын гүйцэтгэлийн тасралтгүй сайжруулалтыг дэмжинэ.

7.6 Баримтжуулсан мэдээлэл

7.6.1 Ерөнхий зүйл

Байгууллагын ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд дараах мэдээлэл багтана. Үүнд:

- энэхүү олон улсын стандартад шаардсан баримтжуулсан мэдээлэл;
- ЗХАБ-ын менежментийн тогтолцооны үр нөлөөтэй байдлыг хангахад шаардлагатай гэж байгууллагаас тодорхойлсон баримтжуулсан мэдээлэл.

ТАЙЛБАР ЗХАБ-ын менежментийн тогтолцооны баримтжуулсан мэдээллийн хэр хэмжээ дараах нөхцөл байдлаас хамааран байгууллага бүрт өөр байх боломжтой. Үүнд:

- байгууллагын хэмжээ болон
- үйл ажиллагаа, үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл,
- үйл явцын төвөгшил болон харилцан үйлчлэл, болон
- ажилтны чадамж.

7.6.2 Мэдээллийг бий болгох, шинэчлэх

Баримтжуулсан мэдээллийг бий болгож шинэчлэхдээ дараах зүйлийг тодорхой болгоно. Үүнд:

- тэмдэглэгээ ба тайлбар (нэр, огноо, зохиогч, дугаар гэх мэт);
- хэлбэр (хэл, программ хангамжийн хувилбар, график гэх мэт) ба зөөгч (цаас, цахим гэх мэт);
- тохиромжтой болон зохистой байдалд дүн шинжилгээ хийх, батлах.

7.6.3 Баримтжуулсан мэдээллийн хяналт

ЗХАБ-ын менежментийн тогтолцоо болон олон улсын энэхүү стандартын дагуу байвал зохих баримтжуулсан мэдээллийг дараах зорилгоор хянана. Үүнд:

- шаардлагатай үед, шаардлагатай газар, хүртээмжтэй болон тохиромжтой хэлбэрээр байгаа эсэх;
- зохих хэмжээнд хамгаалагдсан эсэх (нууц алдагдах, буруугаар ашиглах, бүрэн бүтэн байдал алдагдах зэргээс).

Баримтжуулсан мэдээллийг хянахын тулд байгууллага дараах үйл ажиллагаанд анхаарна. Үүнд:

- түгээх, нэвтрэх, сэргээх, ашиглах;
- хадгалах, хамгаалах, тухайлбал гаргацтай байдлыг хамгаалах;
- өөрчлөлтийг хянах (хэвлэлийн хяналт зэрэг);
- архивлах ба устгах.

ЗХАБ-ын менежментийн тогтолцооны төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд шаардлагатай гадны эх үүсвэр бүхий баримтжуулсан мэдээллийг байгууллага зохих хэмжээнд тодорхойлж, хянана.

ТАЙЛБАР Нэвтрэх гэж баримтжуулсан мэдээллийг зөвхөн үзэх, эсвэл үзэж өөрчлөлт оруулах гэх мэт зөвшөөрөл, эрх мэдэл олгохыг ойлгоно.

8 Ажиллагаа

8.1 Ажиллагааны төлөвлөлт ба хяналт

Байгууллага нь шаардлагыг хангах, мөн 6.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, 6.3-т тодорхойлсон ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлд анхаарах, 6.4-т заасан ЗХАБ-ын зорилтууд, зорилтот үр дүнд хүрэх үйл явцыг тодорхойлж, төлөвлөж, хэрэгжүүлж, хянахын тулд:

- үйл явцын шалгуурыг тогтоох;
- шалгуурын дагуу үйл явцыг хянах;
- үйл явц төлөвлөсний дагуу явагдсан гэдэгт итгэлтэй байхын тулд баримтжуулсан мэдээллийг шаардлагатай хэмжээгээр хөтөлж хадгална.

Байгууллага нь төлөвлөгөөний дагуух өөрчлөлтөд хяналт тавих, хүсээгүй өөрчлөлтийн үр дагаврыг хянаж, шаардлагатай бол аливаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авна.

Байгууллага нь хавсран гүйцэтгүүлж байгаа үйл явцыг хяналтанд байлгана.

8.2 Онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээ

Байгууллага нь зам тээврийн осол эсвэл тухайн байгууллага холбогдсон бусад зам тээврийн аюултай тохиолдлын шалтгаантай нас баралт, хүнд гэмтлийн үед хариу арга хэмжээ авч, боломжтой бол, ЗХАБ-ын аливаа сөрөг нөлөөллөөс сэргийлэх эсхүл үр дагаварыг багасгах үүрэгтэй.

Байгууллага нь аливаа зам тээврийн осол эсхүл тухайн байгууллагын холбогдох бусад зам тээврийн тохиолдлын шалтгаантай нас баралт, хүнд гэмтлийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээнд, тухайлбал ийм нас баралт эсхүл хүнд гэмтлийн дараа, тодорхой давтамжтайгаар дүн шинжилгээ хийж, шаардлагатай гэвэл шинэчилнэ. Байгууллага нь боломжтой бол эдгээр журмыг тодорхой давтамжтайгаар туршдаг байна.

9 Гүйцэтгэлийн үнэлгээ

9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ

Байгууллага нь ЗХАБ-ын менежментийн тогтолцооны дараахь зүйлийг тодорхойлно.

- юуг хянах, хэмжих шаардлагатай;
- үр дүнг баталгаатай байлгахын тулд мониторинг, хэмжилт, шинжилгээ хийх, үнэлэх аргууд;
- мониторинг, хэмжилтийг гүйцэтгэх хугацаа;
- мониторинг, хэмжилтийн үр дүнд шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа.

Байгууллага үр дүнгийн талаар баримтжуулсан мэдээллийг нотолгоо болгон хөтөлж хадгална.

Байгууллага нь ЗХАБ-ын гүйцэтгэл болон ЗХАБ-ын менежментийн тогтолцооны үр нөлөөг үнэлнэ.

Байгууллага нь ЗХАБ-ын холбогдох хууль эрх зүйн шаардлага болон тухайн байгууллагад хамааралтай бусад шаардлагын нийцэлд тодорхой давтамжтай үнэлэх үйл явцыг бий болгож, хэрэгжүүлж, хадгална.

9.2 Зам тээврийн осол ба зам тээврийн бусад тохиолдлын судалгаа

Байгууллага нь замын хөдөлгөөнд оролцогчдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан, эсхүл хүргэж болзошгүй зам тээврийн осол, холбогдсон бусад тохиолдлыг бүртгэх, судлах, шинжилгээ хийх журам(ууд)-ыг дараах зорилгоор бий болгох, хэрэгжүүлэх, хадгална:

- а) хяналт тавих ба/эсхүл нөлөөлж болох, эдгээр тохиолдлууд гарахад нөлөөлсөн эсвэл хувь нэмэр оруулсан байж болох суурь хүчин зүйлсийг тодорхойлох;
- б) ЗХАБ-ын залруулах арга хэмжээний хэрэгцээг тодорхойлох;
- в) ЗХАБ-ын сэргийлэх арга хэмжээ авах боломжийг тодорхойлох.

Судалгааг цаг тухайд нь хийнэ.

Энэхүү стандартын 10-р бүлгийн холбогдох заалтуудын дагуу ЗХАБ-ын тогтоосон залруулах арга хэмжээний хэрэгцээ эсхүл сэргийлэх арга хэмжээний боломжуудыг авч үзнэ.

Зам тээврийн осол болон бусад тохиолдлын судалгааг баримтжуулж, мөрдөж хадгална.

9.3 Дотоод аудит

Байгууллага ЗХАБ-ын менежментийн тогтолцооны байдлын талаар дараах мэдээллийг авахын тулд төлөвлөсөн хугацаанд дотоод аудит хийнэ. Үүнд:

- а) доорх шаардлагад тохирч байгааг. Үүнд:
 - 1) ЗХАБ-ын менежментийн тогтолцооны байгууллагын өөрийн шаардлага;
 - 2) олон улсын энэхүү стандартын шаардлага;
- б) үр нөлөөтэй хэрэгжиж, хадгалагдаж байгааг.

Байгууллага нь:

- давтамж, аргачлал, хариуцлага, төлөвлөх шаардлага, тайлагнал зэргийг тусгасан аудитын хөтөлбөрийг төлөвлөж, бий болгох ба хэрэгжүүлж, хадгална. Аудитын хөтөлбөрийг боловсруулахад холбогдох үйл явцуудын ач холбогдол, өмнөх аудитын үр дүнг авч үзнэ;
- аудит тус бүрийн шалгуур, хамрах хүрээг тогтооно;
- аудиторуудыг сонгох, аудитыг бодитой, шударга явуулна;
- аудитын үр дүнг холбогдох удирдлагад мэдээлнэ;
- аудитын хөтөлбөр хэрэгжсэн тухай болон аудитын үр дүнгийн нотолгоо болох баримтжуулсан мэдээллийг хадгална.

9.4 Удирдлагын дүн шинжилгээ

Дээд удирдлага ЗХАБ-ын менежментийн тогтолцоо нь байгууллагын тогтоосон ЗХАБ-ын зорилтууд болон зорилтот үр дүнд тохирсон, нийцсэн, үр бүтээлтэй, уялдаатай байгаа эсэхэд дүн шинжилгээг тодорхой давтамжтай хийнэ.

Байгууллага нь ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгох, эсвэл ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд хийсэн дүн шинжилгээний дагуу арга хэмжээ авахдаа тухайн байгууллагын ЗХАБ-ын үйл ажиллагааг дунд болон урт хугацаанд сайжруулах зорилго бүхий менежментийн тогтолцооны хүрээнд шийдвэрлэх шаардлагатай гол асуудлуудыг тодорхойлж, шинжилгээ хийнэ.

Удирдлагын дүн шинжилгээнд дараах асуудлуудыг авч үзнэ. Үүнд:

- а) өмнөх удирдлагын дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээний тухай;
- б) ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд хамаарах гадаад болон дотоод асуудлуудад гарсан өөрчлөлтүүд;
- в) ЗХАБ-ын зорилтууд, зорилтот үр дүнд хэр хүрсэн, аудитын үр дүн, хууль тогтоомжийн болон байгууллагад хамаарах бусад шаардлагын нийцэл багтсан үл тохирол, залруулах арга хэмжээ, мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээний үр дүнгийн чиг хандлагын талаарх ЗХАБ-ын гүйцэтгэлийн мэдээлэл;
- г) шинэ технологийг авч үзэх зэрэг тасралтгүй сайжруулах боломж;
- д) гомдлыг зэрэг сонирхогч талуудаас ирсэн холбогдох мэдээлэл;
- е) зам тээврийн осол ба бусад зам тээврийн тохиолдлууд;

Удирдлагын дүн шинжилгээний үр дүнд сайжруулах боломжууд, ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд оруулах аливаа өөрчлөлтийн хэрэгцээтэй холбоотой арга хэмжээний талаарх шийдвэрүүд гарсан байна.

Байгууллага удирдлагын дүн шинжилгээний үр дүнгийн нотолгоо болгон баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

10 Сайжруулалт

10.1 Үл тохирол ба залруулах арга хэмжээ

ЗХАБ-ын менежментийн тогтолцооны шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд байгууллага нь:

- а) үл тохирлын дагуу хариу арга хэмжээ авч, шаардлагатай бол түүнийг хянах, засах, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах;
- б) үл тохиролд дүн шинжилгээ хийх, шалтгааныг тодорхойлох, ижил төстэй үл тохирол байгаа эсэх, эсвэл үүсч болзошгүй эсэхийг тодорхойлох замаар үл тохирлын шалтгааныг арилгах, дахин давтагдах эсвэл өөр газар тохиолдахгүйн тулд арга хэмжээ авах хэрэгцээг үнэлэх;
- в) шаардлагатай аливаа арга хэмжээг хэрэгжүүлэх;
- г) аливаа залруулах арга хэмжээний үр нөлөөнд дүн шинжилгээ хийх;
- д) шаардлагатай бол ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулах.

Залруулах арга хэмжээ нь үл тохирлын үр дагаварт тохирсон байх ёстой.

Байгууллага нь үл тохирлын шинж чанар, түүний дагуу хэрэгжүүлсэн аливаа арга хэмжээ, залруулах арга хэмжээний үр дүнгийн нотолгоо болгон баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

10.2 Байнгын сайжруулалт

Байгууллага нь ЗХАБ-ын менежментийн тогтолцооны зохистой, тохиромжтой, үр нөлөөтэй байдлыг байнга сайжруулдаг байна.

Тайлбар: ЗХАБ-ын бодлого, зорилтууд, зорилтот үр дүн, аудитын үр дүн, мониторинг хийсэн зүйлд шинжилгээ хийх, залруулах болон сэргийлэх арга хэмжээ, удирдлагын дүн шинжилгээг хийх замаар үүнийг хэрэгжүүлж болно.

А хавсралт

(мэдээллийн)

Энэхүү олон улсын стандартыг хэрэглэх заавар

A1 Ерөнхий зүйл

Энэхүү хавсралт нь мэдээллийн чанартай ба энэхүү стандартын 4-10 дугаар зүйлд заасан шаардлагыг тайлбарлах зорилготой юм. Эдгээр мэдээллийг 4-10 дугаар бүлгийн шаардлагад нэмж оруулах, хасах, өөрчлөхөд зориулаагүй.

ЗХАБ-ын зорьсон үр дүнд хүргэхийн тулд ЗХАБ-ын менежментийн зохистой дадалд үр нөлөөтэй арга хэмжээ авахад шаардлагатай тодорхой чадавхи бүхий удирдлагын гол чиг үүрэг, үйл явц бүхий системтэй арга барилтай байхыг шаарддаг.

ЗХАБ-ын менежментийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлэхэд тухайн байгууллагын эсхүл байгууллагын нэрийн дор ажиллаж байгаа стратегийн удирдлагаас эхлээд үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа ажилтан хүртэлх бүх хүмүүсийн үүрэг амлалтаас хамаарна.

Энэхүү үүрэг амлалт нь удирдлагын дээд шатнаас эхэлдэг. Энэхүү олон улсын стандартад ЗХАБ-ын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн, Хавсралт Б-д тодорхойлсон Аюулгүй тогтолцооны аргыг дэмжсэн ЗХАБ-ын менежментийн тогтолцоог тодорхойлсон. ЗХАБ-ын менежментийн тогтолцоо нь дээд удирдлагаас сайн манлайлал, үүрэг амлалт (5-р бүлгийг үзнэ үү)-ыг шаарддаг мөчлөг бүхий Төлөвлө-Гүйцэтгэ-Шалгах-Сайжруул арга зүйд суурилсан.

Энэхүү байнгын сайжруулах үйл явцын хурд, цар хүрээ, хугацааг эдийн засгийн болон бусад нөхцөл байдалтай уялдуулан байгууллага тодорхойлдог.

а) 1-р алхам: Төлөвлө

- Байгууллагын ЗХАБ-д үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, эдгээр нь сонирхсон талуудад хэрхэн нөлөөлөх талаар зураглалыг гаргах, төлөвлөлтийн явцад тодорхойлсон хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ЗХАБ-ын менежментийн тогтолцоог зохион байгуулах хамрах хүрээг тодорхойлно (4-р зүйлийг үзнэ үү).

ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах болон байнгын сайжруулахад чиглэсэн бусад арга хэмжээнүүдийн зэрэгцээ ЗХАБ-ын зорилтот үр дүн, стратеги эсхүл үүнд хүрэх аргыг тодорхойлох болон шаардлагатай нөөцөөр хангах замаар нас баралт, хүнд гэмтлийг арилгах урт хугацааны алсын хараанд хүрэх удирдлагын үүрэг амлалтыг бий болгоно.

ЗХАБ-ын менежментийн тогтолцооны бодлогыг тогтоох, баримтжуулах, мэдээлэх, зохион байгуулалтын үүрэг, хариуцлага, эрх мэдлийг тодорхойлно (5-р бүлгийг үзнэ үү).

- Одоогийн гүйцэтгэлийг боломжийн хэрээр үнэлэх замаар эрсдэл, боломжуудыг тодорхойлж, ЗХАБ-ыг гүйцэтгэлийн хүчин зүйл тус бүрийг авч үзэн тухайн байгууллагад хамааралтай болон хамгийн чухлыг тогтооно. ЗХАБ-ын менежментийн хүчин чадлын хэрэгцээнд тулгуурлан ЗХАБ-ын хамгийн чухал гүйцэтгэлийн хүчин зүйл

бүрээр ЗХАБ-ын зорилтууд (хэмжих боломжтой, боломжтой бол) болон хэмжиж болох ЗХАБ-ын зорилтот үр дүнг тогтоож, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна (6-р бүлгийг үзнэ үү).

б) Алхам 2: Хий

ЗХАБ-ын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, ЗХАБ-ын зорилтууд болон зорилтот үр дүнд хүргэх 7, 8-р бүлэгт заасан алхмуудын дагуух тогтолцооны гол чиг үүргийг хэрэгжүүлэх хангалттай хүчин чадалтай байх нөхцлийг хангана.

в) Алхам 3: Шалга

9-р бүлэгт заасан алхмуудын дагуу ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд шаардлагатай байнгын сайжруулалт хийх, ЗХАБ-ын үр дүнд хүрэх, өөрчлөх боломжуудыг тодорхойлохын тулд ЗХАБ-ын гүйцэтгэлд мониторинг хийх, үнэлэлт өгөх, ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээг тодорхой давтамжтай хийнэ.

д) 4-р алхам: Сайжруул

ЗХАБ-ын зорилтууд болон зорилтот үр дүнд үндэслэн ЗХАБ болон ЗХАБ-ын менежментийн тогтолцооны гүйцэтгэл, дутагдал, үл тохиролд дүн шинжилгээ хийх болон зам тээврийн ослын үеийн нас баралт, ноцтой гэмтлийн тохиолдох эрсдэлийг бууруулахад чиглэсэн залруулах болон сэргийлэх арга хэмжээ авах боломжийг тодорхойлох замаар ЗХАБ-ын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулах (10-р бүлгийг үзнэ үү).

А.2 Норматив иш таталт

Зааварчилгаа өгөөгүй.

А.3 Нэр томъёо ба тодорхойлолт

Зааварчилгаа өгөөгүй.

А.4 Байгууллагын төлөв байдал

Суурь үнэлгээ нь ЗХАБ-ын байгууллагын одоогийн төлөв байдлыг тодорхойлдог. Үнэлгээгээр ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгоход хамааралтай бүх хүчин зүйлийг авч үзэх ба үүнд байгууллагын хүсч буй ЗХАБ-ын үр дүн, хэрхэн хүргэх, хэн хариуцах зэрэг багтана. Үнэлгээ хийх арга хэрэгсэлд хяналтын хуудас, ярилцлага, санал асуулга, шалгалт, хэмжилт, өмнөх аудитын үр дүн, бусад үнэлгээ, хяналт орно.

А.4.1 Байгууллага ба түүний төлөв байдлыг ойлгох

ЗХАБ-ын төлөв байдал дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс хамаарна, тухайлбал зам, зам дээрх тээврийн хэрэгсэл, зам, тээврийн хэрэгслийн ашиглалт, яаралтай тусламж, гэмтлийн тусламж, нөхөн сэргээлт зэрэг харилцан үйлчлэлээр тодорхойлж болно. Эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрийг олон байгууллага хянадаг ба/эсвэл нөлөөлөлд өртдөг бөгөөд энэ нь эцэстээ ЗХАБ-д нөлөөлдөг. Байгууллагын ЗХАБ-д үзүүлэх нөлөө нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, хаана, ямар нөхцөлд ажиллаж байгаа, түүнчлэн ЗХАБ-ын менежментийн тогтолцооны

үр дүнтэй байдлаас хамаарна.

Төрийн болон хувийн хэвшлийн, том, жижиг байгууллагуудын үйл ажиллагааны жишээг дор жагсаав. Ихэнх ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлүүд нь бүх байгууллагад хамааралтай боловч тэдгээрийн ач холбогдол нь байгууллагаас хамаарч өөр өөр байдаг.

а) Ажилтан ажилдаа ирэх, буцах, жижүүр хийхдээ нийтийн болон хувийн тээврийн хэрэгслээр зорчигч, жолоочтой явах, явган явах, дугуй унах үед замын хөдөлгөөний системийг ашиглах.

б) Байгууллагын гүйцэтгэж байгаа, эсхүл бусад байгууллагатай гэрээ байгуулсан авто замын хөдөлгөөний сүлжээний бараа, зорчигч тээвэрлэлт.

в) Супермаркет, сургууль, олон зочинтой байршил гэх мэт байгууллагын хяналтанд байдаг эсвэл нөлөөлөлд өртсөн газрууд руу чиглэсэн хөдөлгөөнийг бий болгодог үйл ажиллагаа.

г) Зам тээврийн үйлчилгээ, удирдлага, төлөвлөлт, зураг төсөл, барилга угсралт, дэд бүтэц, тээврийн хэрэгсэл болон холбогдох бүтээгдэхүүн, эмнэлгийн яаралтай хариу арга хэмжээ, гэмтлийн тусламж үйлчилгээ, нөхөн сэргээлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, хууль тогтоомжийн үйл ажиллагаа зэрэг замын хөдөлгөөний тогтолцооны үйлчилгээ, бүтээгдэхүүн.

Хэдийгээр зарим байгууллагад ЗХАБ-тай холбоотой цөөн тооны үйл явц байдаг ч эдгээр нь нас баралт, хүнд гэмтлийг бууруулахад маш чухал ач холбогдолтой юм. Иймд мотортой болон моторгүй тээврийн хэрэглэгчдийн хэрэгцээ, эрсдэлд өртөх түвшинг тодорхойлох нь чухал юм. Гадны тодорхой асуудлуудыг зам тээврийн осол, гуравдагч этгээдийн гомдлоор хүлээн зөвшөөрч болно. Баримтжуулсан журмын дагуу алдаа гарах эсвэл хазайх зэргээр дотоод асуудлуудыг таньж болно.

А.4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг ойлгох

Байгууллага дахь ихэнх үйл ажиллагаа, чиг үүрэг(үйл явц)-ийг байгууллага өөрөө удирдлагаар хангана.

Гэсэн хэдий ч нас баралт, хүнд гэмтлийг бууруулах нь хэд хэдэн байгууллага, замын хөдөлгөөнд оролцогчдын үйл ажиллагааны нэгдэл, харилцан үйлчлэлээс хамаарна. Тиймээс байгууллага нь нас баралт, хүнд бэртлийг бууруулахад хамгийн их хамааралтай хүмүүстэй харилцах, зөвлөлдөх, зохицуулах зорилгоор өөрийн нөлөөллийн хүрээнд сонирхогч талуудыг тодорхойлох ёстой.

А.4.3 Менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох

Байгууллага нь энэхүү олон улсын стандартыг байгууллага бүхэлд нь эсвэл тухайн байгууллагын үйл ажиллагааны тодорхой нэгжүүдэд хэрэгжүүлэхээр сонгож болно. Байгууллага нь ЗХАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээг, ялангуяа байгууллага бүхэлдээ биш бол ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд хамаарах байгууллагын нэгж, хэсгүүдийг тодорхойлж, баримтжуулах ёстой. Хамрах хүрээг тодорхойлсны дараа тухайн хамрах хүрээний байгууллагын бүх үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд оруулах

шаардлагатай. ЗХАБ-ын менежментийн тогтолцооны найдвартай байдал нь ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд байгууллагын аль хэсэг багтсан, мөн хассан баримтжуулсан шалтгаанаас хамаарна.

А.4.4 ЗХАБ-ын менежментийн тогтолцоо

Зааварчилгаа өгөөгүй.

А.5 Манлайлал

А.5.1 Манлайлал ба үүрэг амлалт

Дээд удирдлагын өндөр түвшний үүрэг амлалт ЗХАБ-ын менежментийн тогтолцооны амжилтад хүрэхэд тулд маш чухал юм. Учир нь доод түвшний үйл ажиллагаа (жишээлбэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, аюулгүй байдлын сургалтын шаардлага) хэрэгжүүлж нас баралт, хүнд гэмтлийг бууруулж, ослын үед хурдан хариу арга хэмжээ авсанаар ЗХАБ-ын менежментийн зорилго биелдэг. Дээд удирдлагын манлайллыг дараахь байдлаар харуулж болно: ЗХАБ-ын менежментийн тогтолцоог үр дүнтэй болгоход хувь нэмрээ оруулах хүмүүсийг урамшуулах, чадваржуулах; ЗХАБ-ын үр дүнд хүргэх байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх; Байгууллагын ЗХАБ-ын зорилгыг хэрэгжүүлэхэд хүмүүсийн оролцоог бүрэн хангах, үлгэр жишээ болохуйц дотоод орчныг бүрдүүлэх, хадгалах.

А.5.2 Бодлого

Байгууллагын ЗХАБ-ын нөхцөл байдал, нас баралт, хүнд гэмтлийг арилгахад оруулсан хувь нэмрийг нь харгалзан ЗХАБ-ын бодлогыг боловсруулах шаардлагатай байна. ЗХАБ-ын бодлого нь ЗХАБ-ын зорилтот үр дүн болон ЗХАБ-ын зорилтуудыг тодорхойлох хүрээг бүрдүүлдэг бөгөөд байгууллагын ЗХАБ-ын менежментийн тогтолцооны хэрэгжилт, сайжруулалтыг удирдан чиглүүлдэг бөгөөд ингэснээр ЗХАБ-ын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулдаг. Сайн практикт энэхүү бодлого нь дээд удирдлагын зүгээс нас баралт, хүнд гэмтлийг арилгах, холбогдох хууль эрх зүйн болон бусад шаардлагыг мөрдөх, байнгын сайжруулалт хийх үүрэг амлалтыг тусгасан байдаг. ЗХАБ-ын бодлого нь дотоод болон гадаад сонирхогч талуудад ойлгомжтой байхуйц тодорхой бөгөөд өөрчлөгдөж буй нөхцөл, мэдээллийг тусгахын тулд үе үе хянаж, шинэчилж байх ба байгууллагын өвөрмөц нөхцөл байдлыг тусгасан тодорхой хамрах хүрээтэй байна.

ЗХАБ-ын бодлого нь байгууллагын бусад бодлогын баримт бичигтэй уялдсан, байгууллагын ерөнхий бизнесийн бодлогыг дагаж мөрдөхөөс гадна бусад хэсгийн бодлоготой (чанарын менежмент, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны менежмент гэх мэт), хууль эрх зүйн шаардлага, салбарын стандарттай нийцсэн байх нь зүйтэй. Сайн туршлагаас харахад байгууллагын дээд удирдлага ЗХАБ-ын үүрэг амлалт тууштай хэрэгжиж байгааг харуулах, бодлогын мэдэгдэлд өгсөн

амлалтуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, ЗХАБ-ын менежментийн тогтолцоо яагаад бий болж, хадгалагдаж байгааг тайлбарлах, хувь хүмүүсийг идэвхжүүлэх байдлаар бодлогоо танилцуулж тэдний ЗХАБ-ын үүрэг, хариуцлагын талаарх ойлголтыг удирдан чиглүүлдэг.

А.5.3 Зохион байгууллалтын үүрэг хариуцлага, эрх мэдэл

ЗХАБ-ын менежментийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлэх нь ЗХАБ-ын хүссэн үр дүнг гаргахад шаардлагатай удирдлагын үндсэн чиг үүрэг, үйл явцыг хэрэгжүүлэх чадварлаг, хариуцлагатай чадамжийг бий болгоход чиглэнэ. Дээд удирдлага нь ЗХАБ-ын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх тодорхой хариуцлага, эрх мэдэл бүхий нэг буюу хэд хэдэн тодорхой удирдлагын төлөөллийг томилох шаардлагатай. ЗХАБ-ын менежментийн тогтолцооны гол үүрэг, хариуцлагыг сайтар тодорхойлж, байгууллагын төлөө болон түүний өмнөөс ажиллаж буй бүх хүмүүст хүргэх нь чухал юм.

А.6 Төлөвлөлт

А.6.1 Ерөнхий зүйл

Зааварчилгаа өгөөгүй.

А.6.2 Эрсдэл, боломжуудад чиглэсэн арга хэмжээ

Тодорхойлсон эрсдэл, боломжийн дагуу үр дүнтэй ажиллах нь зам тээврийн ослын шалтгаантай нас баралт, хүнд гэмтлийг бууруулснаар байгууллагын зардал багасч, үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулах цаг, нөөцийг нэмэгдүүлэх болно. Энэ нь мөн сонирхогч талуудын байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх хандлагатай.

Эрсдэл ба боломжуудын жишээнүүд настай хэрэглэгчдийн эзлэх хувь өндөр, моторт болон моторгүй тээврийн хэрэгсэл бүхий холимог хэрэглэгчид, гол чиглэлүүдэд хөдөлгөөний ачаалал их, үйлчлүүлэгчдээс хүргэлтийг цагт авахыг хүссэн хатуу шаардлага, янз бүрийн бүс нутаг дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын үйл ажиллагаанууд, аюулгүй байдлын үндсэн дүрмүүдийн нийцлийн түвшин болон замын дэд бүтэц, тээврийн хэрэгслийн парк, эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцооны чанар гэх мэт хамаарна.

А.6.3 ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлүүд

ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлүүдэд байгууллагууд өөрсдийн ЗХАБ-ын менежментийн тогтолцоонд анхаарах ёстой замын хөдөлгөөний аюулгүй байдлын янз бүрийн элементүүдийг тайлбарласан. Энэхүү олон улсын стандартад тодорхойлсон ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлүүд нь ихэнх байгууллага, нөхцөл байдалд хэрэглэгдэх боломжтой ерөнхий шинжтэй ба нотолгоонд суурилсан ЗХАБ-ын нийтлэг асуудал болон шийдэлд хандсан. Байгууллага нь өөрийн төлөв байдалд тулгуурлан дараах гүйцэтгэлийн бүх хүчин зүйлийг авч үзэн эрэмбэлнэ.

а) Эрсдлийн хүчин зүйлүүд: Байгууллага нь замын хөдөлгөөний тогтолцоонд аюулгүй байдлын эрсдэлд хэр өртөж байгааг авч үзэн, энэ талаарх өгөгдлийг цуглуулах шаардлагатай. Тухайн байгууллагад хамааралтай тодорхой бүсийн хэмжээн дэх хөдөлгөөний багтаамж, байгууллагын ажилтнуудын аяллын багтаамж эсхүл бүтээгдэхүүн, үйлчилгээний багтаамж гэх мэт эрсдлийн хүчин зүйлүүд нь янз бүрийн хэлбэртэй байж болно. Аюулгүй байдлын эрсдлийг тухайн хэрэглэгчдийн төрөл, жолоодлогын бүртгэл зэрэг бусад хүчин зүйлээс хамаарч нэмэгдүүлж эсвэл бууруулж болно. Аюулгүй байдлын эрсдэлийг мөн тээврийн хэрэгслийн төрөл, тээврийн төрлөөс хамааран нэмэгдүүлж эсвэл бууруулж болно. Аюулгүй байдлын эрсдлийн хэмжээг ойлгох нь байгууллагуудад гүйцэтгэлийн хүчин зүйлсийн алийг нь нэн түрүүнд тавьбал зохих ёстой бодит мэдээллийг өгдөг.

б) Аюулгүй байдлын эцсийн үр дүнгийн хүчин зүйлүүд: зам тээврийн ослын шалтгаантай нас баралт болон ноцтой гэмтлийн хэмжээ, түүний үр дүнгийн хүн болон эдийн засгийн хохирлыг авч үзэх, энэ талаарх мэдээлэл цуглуулах зэрэг нь зохистой дадалд хамаарна.

Аюулгүй байдлын эцсийн үр дүнгийн хүчин зүйлүүдэд бие махбодийн гэмтлээс гадна зөвхөн байгууллагад хамаарах бүтээмж алдагдах, нэмэлт гадны зардал эсхүл өвдөх, шаналах, үйлчилгээг сэргээх, хүн нөхөн сэргэх, эмчилгээ болон сэргээн засал гэх мэт нийгэм эдийн засгийн томоохон хохирлуудыг авч үзэх боломжтой. Хүн болон эдийн засгийн хохирлын хэмжээг ойлгох нь байгууллагуудад ЗХАБ-ыг сайжруулснаар гарах ашиг тус, үр ашгийн талаарх бодит мэдээллийг өгдөг.

в) Аюулгүй байдлын завсрын хүчин зүйлүүд: Замын хөдөлгөөний тогтолцоо нь олон оролцогчтой, хамтын үүрэг хариуцлага бүхий нээлттэй, цогц систем юм. Нас баралт эсхүл ноцтой гэмтэл учруулах зам тээврийн осол ховор тохиолддог ба арга хэмжээ авах орон зай ба цаг хугацаа болон боломжит сайжруулалт хоорондох зай их байж болно.

Эрсдлийн болон аюулгүй байдлын эцсийн хүчин зүйлст байнга мониторинг хийх шаардлагатай ч аюулгүй байдлын завсрын хүчин зүйлүүд (аюулгүй байдлын эцсийн хүчин зүйлүүдтэй учир шалтгааны холбоотой)-эд хамгийн их анхаарал хандуулах шаардлагатай. Аюулгүй байдлын завсрын үр дүн гэж замын хөдөлгөөний хурдыг бууруулах эсхүл тээврийн хэрэгслийн паркийн аюулгүй байдлын зэрэглэлийг (Шинэ автомашины үнэлгээний хөтөлбөр гэх мэт) сайжруулах зэрэг ЗХАБ-ын эцсийн гүйцэтгэлийг сайжруулдаг хөндлөнгийн оролцооны арга хэмжээ юм. Завсрын хүчин зүйлүүдэд анхаарлаа төвлөрүүлэх, хэмжих, дагаж мөрдөх нь ЗХАБ-ын гүйцэтгэлийн хамгийн сайн сайжруулалт болох ба байнгын сайжруулалтад хүрч болно.

Байгууллага нь өөрийн төлөв байдалд тохируулан дараах жагсаалтыг ашиглах аюулгүй байдлын завсрын хүчин зүйлсийг тодорхойлбол зохино.

1) Тусгаарлах (эсрэг урсгал болон замын эмзэг хэрэглэгчид), замын хажуугийн хэсэг болон уулзварын зургийн стандартууд, замын сүлжээний аюулгүй төлөвлөлт, зураг төсөл, барилга угсралт, ашиглалт, ажиллагаа, засвар үйлчилгээнд хамаарах удирдамж болон нийцлийн арга хэмжээ зэргийг авч үзсэн замын зураг төсөл ба аюулгүй хурд.

Аюулгүй тогтолцооны шаардлагыг хангасан, үр дүнтэй, шинэлэг арга хэмжээнүүдийг аюулгүй байдлын инженерийн бодлого, төлөвлөгөө болон замын дэд бүтцийн аюулгүй байдлын чанарыг үнэлэхэд туслах шинэ хэрэгслийг дэмжихэд улам бүр ашиглаж байна. Урсгал зам, хуваарилах болон нэвтрэх чиг үүрэг бүхий зам, гудамжуудын аюулгүй байдлын асуудал болон тавигдах шаардлагууд өөр өөр байна. Тухайн замын чиг үүрэг, аюулгүй хурдны хязгаарлалт болон тэдгээрийн хууль тогтоомжид нийцсэн байдал, зураг төсөл ба зохион байгуулалтын хоорондын уялдааг сайн хангаж чадвал аюулгүй байдлын өндөр түвшинд хүрч чадна. Мөргөлдөхөөс сэргийлэхийн тулд өндөр ачаалалтай, өндөр хурдтай зам дээр эсрэг урсгалыг тусгаарлах, мөргөлдөж замын хажуу руу орох ослоос сэргийлэх замын хажуугийн хамгаалалтыг хийх зэрэг нь ердийн асуудлуудын жишээ юм;

хажуугаар мөргөлдөх явдлыг багасгах зорилгоор уулзвар дээрх аюулгүй хурдыг хангуулах, тээврийн хэрэгсэл болон замын эмзэг оролцогчдыг тусгаарлах нь төвөгтэй холимог зам, гудамжинд аюулгүй хурдыг хангуулах.

Олон улс оронд замын аюулгүй байдлын түвшин болон хуулиар тогтоосон хурдны хязгаар хооронд ихээхэн зөрүүтэй байдаг. Байгууллагууд хурдны хязгаарлалт тогтоох талаар авч үзэх боломжтой.

2) Тээврийн хэрэгслийн төрөл, хэрэглэгч, ачаа болон тоног төхөөрөмжийн төрөлд тохирох замыг ашиглах

Зарим төрлийн тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн хувьд (аюултай зэрэг тодорхой ачаа тээвэрлэдэг гэх мэт) зарим төрлийн замд нэвтрэх нь тохиромжгүй байдаг тул тохирсон замыг зохих ёсоор сонгож ашиглана.

3) Хамгаалах бүс, хүүхдийн суудал, унадаг дугуй, мотоциклийн малгай, харах болон үзэгдэхэд зориулсан хэрэгслийг авч үзсэн хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд хамгаалах бүс, унадаг дугуй, мотоциклийн ослын хамгаалах малгай, үзэгдэх хэрэгсэл, мотоциклийн жолоочийн хамгаалах хувцас, хүүхдийн аюулгүй байдлын тусгай хэрэгсэл зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл зайлшгүй шаардлагатай.

Аюулгүй хэрэглээ нь зөвхөн хэрэглэгч/жолооч, цагдаагийн байгууллагын тусламжтайгаар аюулгүй байдлын үндсэн дүрмийг дагаж мөрдөхөөс гадна заавал хэрэгжүүлэхийг шаардсан арга хэмжээ болон жолоочид туслах төхөөрөмж (хамгаалах бүс бүслэхийг сануулагч гэх мэт) зэргээс хамаарна.

4) Тээврийн хэрэгслийн төрөл, замын хөдөлгөөн, цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан аюулгүй хурдыг баримтлах.

Аюултай хурд нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын гол асуудал юм. Инженерийн болон олон нийтийн сурталчилгаа, дэг журам сахиулах арга хэмжээ авахаас гадна хурдны камер, хурд хязгаарлагч, тээврийн хэрэгслийн хянах төхөөрөмж гэх мэт жолоочид туслах систем зэрэг хурдны хязгаарыг дагаж мөрдөхөд туслах олон төрлийн технологийг ашиглаж болно. Цаг агаар, замын хөдөлгөөний нөхцөлд дасан зохицох, замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх нь угтвар нөхцлүүд юм.

5) Ядрах, анхаарал сарниулах, архи, мансууруулах бодис хэрэглэх зэргийг авч үзсэн жолоочийн жолоо барих бэлэн байдал.

Зам тээврийн ослын дийлэнх хувийг ядрах, анхаарал сарниулах, архи, мансууруулах бодис хэрэглэснээс үүдэлтэй жолоодлого алдсан байдал эзэлж байна. Олон улс оронд хууль тогтоомж болон бусад шаардлагыг тогтоох замаар эдгээр асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг. Сogтуугаар жолоодохоос сэргийлдэг архины түгжээ зэрэг жолоочид туслах системийг улам их ашиглаж байна. Арилжааны тээврийн хэрэгслийн ашиглалт, жолооч нарын ажлын цагийг хянах, бүртгэх нь үр ашигтай менежментийн хэрэгсэл юм.

6) Аюулгүй аяллын төлөвлөлт, үүнд аялах хэрэгцээ, аяллын хэмжээ, хэлбэр, маршрут, тээврийн хэрэгсэл, жолоочийн сонголт зэргийг аялалыг төлөвлөхөд авч үзэх нь ЗХАБ-д чухал нөлөөтэй. Аялал зайлшгүй шаардлагатай эсэх (харилцаа холбооны аргаар шийдэх нь адилхан үр дүнтэй байж болох жишээтэй), ямар хэлбэрээр аялахад (явганаар, хувийн тээврийн хэрэгсэл, нийтийн тээвэр) нь аливаа аялалд хамгийн аюулгүй бөгөөд хамгийн тохиромжтой, аль чиглэл нь хамгийн аюулгүй, хамгийн тохиромжтой вэ гэдгийг анхаарах нь чухал. Хэрэглэгчийн хөтөлбөр (янз бүрийн замын замын аюулгүй байдлыг тогтмол үнэлдэг замын үнэлгээний хөтөлбөр гэх мэт) эсвэл аялал төлөвлөх програм зэргийг ашиглах нь дэмжлэг болдог.

7) Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, үүнд ялангуяа зорчигч болон замын хөдөлгөөний бусад оролцогчид (эмзэг оролцогч болон тээврийн хэрэгслийн бусад зорчигчид)-ыг хамгаалах, зам тээврийн ослоос зайлсхийх, үр дагаварыг бууруулах, тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцох боломжтой байдал, даац, тээврийн хэрэгслийн дотор болон дээрх ачааны аюулгүй бэхэлгээ зэрэг хамаарна.

Аюулгүй байдлын шинэ технологи (тогтвортой байдлын цахим хяналт гэх мэт) хөгжүүлэлт, хэрэглээ зэрэг тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын загвар зохион бүтээлт болон аюулгүйн хэрэгслийн сайжруулалт нь зам тээврийн ослын шалтгаантай нас баралт, хүнд гэмтлийг бууруулахад чухал үүрэгтэй.

Авто замын сүлжээнд тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөлийг харьяаллын тээврийн хэрэгслийн бүртгэл, гэрчилгээжүүлэх хууль тогтоомжид заасан байдаг ба зохион байгуулалтын шаардлагуудыг үүнд нэмэлтээр оруулж болно. Байгууллагууд ашиглаж буй тээврийн хэрэгслийн сонголтыг сайтар хийх замаар аюулгүй байдлаа сайжруулж чадна. Аюулгүй байдлын хувьд дотор нь эсхүл гадна байгаа хүндээ, хөнгөн эсхүл хүнд даацын гэдгээс хамааран тээврийн хэрэгслүүд төрөл, загвараас хамааран ялгаа ихтэй байна.

Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг ерөнхийд нь хуулиар тогтоосон байдаг ба хамгийн сүүлийн үеийн тээврийн хэрэгсэл нь аюулгүй байдлын хууль тогтоомжийн шаардлагыг давсан байдаг. Хэрэглэгчийн хөтөлбөрүүд нь олон төрлийн тээврийн хэрэгслийн төрөл, загварын аюулгүй байдлыг туршиж, зэрэглэснийг нийтэлдэг ба үүнийг байгууллагууд тээврийн хэрэгслийн паркийн аюулгүй байдлын түвшингийн талаар шийдвэр гаргахад ашиглаж болно.

8) Тээврийн хэрэгслийн ангиллын дагуу жолоодох/унах зохих зөвшөөрөл олгох.

Жолооч болон тээврийн хэрэгслийг унадаг хүмүүсийн замын сүлжээнд хууль тогтоомж, стандартын дагуу нэвтэрч, гарна.

Эдгээр стандартыг дагаж мөрдөхийг зохих жолоодох эсхүл унах эрхийн баримт

бичгийг шаардах замаар хангаж болох ба байгууллага нь жолооч болон тээврийн хэрэгсэл унах талаар аюулгүй байдлын нэмэлт шаардлага, жолоочийн зан үйлийн илүү өндөр стандартыг тогтоож болно. Байгууллагууд хэн аль замд ямар тээврийн хэрэгслээр зорчиж болох талаар маш тодорхой шаардлага тогтоож, эдгээр шаардлагыг дагаж мөрдүүлэх талаар зохих арга хэмжээг авсан байвал зохино. Эрүүл мэндийн байдал, чадамж, жолоодох эрхийн стандартууд бүгд чухал байна.

9) Замын сүлжээнээс тохиромжгүй тээврийн хэрэгсэл, жолоочийг чөлөөлөх.

Торгуулийн систем нь аюулгүй байдлын үндсэн дүрмийг ноцтой зөрчсөн тохиолдолд жолоочийн эрхийг хасах нөхцөлийг тодорхойлдог. Хууль тогтоомжид тээврийн хэрэгслийг замаас чөлөөлөх нөхцөлийг тогтоосон байдаг. Байгууллагууд тээврийн хэрэгслийн паркт үзлэг хийх журам, тээврийн хэрэгслийн насжилтын хязгаарлалт, жолоочийн жолоо барихыг үргэлжлүүлэн зөвшөөрөх эсэхийг хянах бүртгэл хөтлөх зэрэг нэмэлт шаардлагыг тавьж болно.

10) Ослын дараах хариу арга хэмжээ, анхны тусламж, онцгой байдлын бэлэн байдал, ослын дараах сэргэлт, сэргээн засалт.

Тохирсон даатгал, аюулын дохионд бэлэн байдал, анхны тусламж үзүүлэх болон худалдаа, нийтийн тээврийн хэрэгслийн жолооч нарын сургалт, аврах, яаралтай тусламжийн үйлчилгээний хүртээмж, чанар, ослын дараах сэргэлт, сэргээн засах арга хэмжээ зэрэг нь ослын нөлөөллийн дараах хариу арга хэмжээний бүрэлдэхүүнд хамаарах ба зам тээврийн ослын дараа нас барах, тахир дутуу болох эсэхэд чухал нөлөөтэй байна.

А.6.4 ЗХАБ-ын зорилтууд ба төлөвлөлт

Байгууллагын төлөв байдлаас үл хамааран ЗХАБ-ын зорилтууд болон зорилтот үр дүнд анхаарлаа төвлөрүүлэх нь менежментийн тогтолцоог хөтөлж, нэгтгэж, зорилго болгодог. ЗХАБ-ын гүйцэтгэлийг сайжруулах нь тасралтгүй үйл явц ба ЗХАБ-ын зорилтууд болон хүрэх үр дүнг хэмжих, түүний талаар хариуцлага хүлээх нь энэхүү сайжруулалтыг хангах хүчин зүйл юм.

Байгууллагын ЗХАБ-ын зорилтууд болон хүрэх зорилтот үр дүн аль болох тодорхой бөгөөд хэмжигдэхүйц байх ба тэдгээрт хүрэхэд шаардлагатай ЗХАБ-ын менежментийн хүчин чадлыг авч үзнэ. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нас баралт, хүнд гэмтэл (эцсийн үр дүн)-ийн тоог бууруулах замаар зам тээврийн ослын зардлыг бууруулах ерөнхий зорилтыг тодорхойлсон байх нь зохистой дадлын жишиг загвар юм.

Эдгээр эцсийн үр дүнд тус бүрдээ ЗХАБ-ын зорилтот үр дүн (хамгаалах бүс зүүсэн түвшин гэх мэт) бүхий аюулгүй байдлын завсрын хүчин зүйлүүдэд суурилсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хүрнэ. Хөндлөнгөөс оролцох эдгээр арга хэмжээнүүд (архины түгжээг суурилуулах гэх мэт үр дүнгүүд) нь тус бүр өөрийн гэсэн ЗХАБ-ын зорилтот үр дүн болон хэмжилтүүдтэй байна.

Нэг буюу хэд хэдэн хөтөлбөр эсхүл үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх нь ЗХАБ-ын менежментийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлэхэд чухал

үүрэгтэй. Нарийн төвөгтэй асуудлын хувьд илүү албан ёсны төсөл, төлөвлөгөө шаардлагатай байж болно. Зохистой дадлуудаас харахад байгууллагууд хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц (санхүү, хүний нөөц, дэд бүтэц)-ийг шалгаж, тэдгээрийг хэрхэн хуваарилах, шаардлагатай зохицуулалтын механизм, хөтөлбөрийг хэрхэн сурталчлах, мониторинг хийх, үнэлж, мэдлэгийг хэрхэн бий болгох, дамжуулах талаар авч үздэг. Хөтөлбөрийн төвөгшлөөс хамааран байгууллага нь ЗХАБ-ын зорилтуудыг хангахад шаардлагатай асуудал тус бүрийн хариуцлага, эрх мэдлийг хуваарилах, хэрэгжүүлсэн байх хугацааг тогтооно. Хөтөлбөр(үүд)-ийн хяналт, сайжруулалтыг тогтмол хийх шаардлагатай. Үүнийг удирдлагын дүн шинжилгээний хүрээнд эсхүл илүү ойрхон давтамжтай хийж болно.

А.7 Дэмжлэг

Амжилттай хэрэгжих ЗХАБ-ын менежментийн тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлж, тогтвортой байлгахын тулд удирдлагын олон чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай.

А.7.1 Зохицуулалт

ЗХАБ-ын менежментийн амжилттай хэрэгжиж байгаа тогтолцоонд байгууллагын нэгжүүд (өөр өөр байршилд байгаа эсвэл өөр өөр чиг үүргийг хариуцдаг) болон сонирхогч талуудыг хэвтээ ба босоо удирдлагаар (төрийн болон хувийн хэвшлийн байгууллага эсэхээс үл хамааран) зохицуулдаг. Байгууллагын төлөв байдал, тухайлбал, сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг ЗХАБ-ын гүйцэтгэлийг сайжруулахад шаардлагатай үйл ажиллагааг зохицуулах боломжтой байх талаар тодорхойлно..

А.7.2 Нөөц

Тэргүүн туршлагуудаас харахад байгууллага нь ЗХАБ-ын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалахын тулд өөрт тохирсон, тогтвортой нөөц, зохион байгуулалтын дэд бүтэцтэй байдаг. Байгууллагын дэд бүтцийн жишээнд барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, холбооны шугам орно. Аюулгүй байдлын хөтөлбөрүүдийн хүрээнд нөөцийн хуваарилалтыг удирдан чиглүүлэхийн тулд зардал-үр ашгийн шинжилгээ зэргийг ашиглаж болно.

А.7.3 Чадамж

Мэдлэг, ур чадвар, ойлголт, чадамжийг сургалт, боловсрол, ажлын туршлага, үзүүлэх төсөл, чадварлаг ажилтныг элсүүлэх замаар олж авах, эсвэл сайжруулах боломжтой. ЗХАБ-ын гүйцэтгэлийг сайжруулж болох аюулгүй байдлын шинэ дадал, арга техник, арга барилыг тогтмол авч үзэхийг дэмжсэн хүнийг нэр дэвшүүлэх эсвэл үйл явцыг бий болгох нь чухал юм. Байгууллага доторх энэхүү ойлголтыг тогтмол шинэчилж байх нь тухайн байгууллагад ЗХАБ-ын талаарх ерөнхий амлалт, арга барилынхаа хүрээнд өөрчлөх практикийг авч үзэх боломжийг олгоно.

А.7.4 Мэдлэг

Дээрх А.7.3 дээрх удирдамжийг үзнэ үү.

А.7.5 Мэдээлэл харилцаа

ЗХАБ-ын менежментийн тогтолцооны шаардлагуудыг мэдээлж харилцах нь түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй. Дотооддоо ажлын хэсгийн тогтмол уулзалт, мэдээллийн хуудас эсвэл дотоод сүлжээний сайтуудаар үүнийг хийж болно.

Боломжит сайжруулалтын талаар зөвлөлдөж, зохих хяналтыг сонгох, тухайлбал тодорхой аюулыг хянах, эсвэл аюултай зан үйлээс сэргийлэх сонголтуудын давуу болон сул талуудын талаар ярилцах замаар хүмүүсийг татан оролцуулж болно.

Гадаад харилцаанд сонирхогч талуудтай яриа хэлэлцээ хийх, тэдний холбогдох ЗХАБ-ын асуудлыг авч үзэх зэрэг байж болно. Энэхүү харилцааны зорилго нь байгууллагууд болон тэдний сонирхогч талууд зохих тохиолдолд ЗХАБ-ыг сайжруулах үүрэг хариуцлагыг хуваалцах боломжтой мэдээлэл, хэтийн төлөвийг нээлттэй солилцохыг дэмжих явдал юм.

Хүссэн ЗХАБ-ын үр дүнд хүрэх нь нийтлэг үүрэг хариуцлага бөгөөд сайн туршлагыг сурталчлах нь ихэвчлэн нас баралт, хүнд гэмтлийг арилгах, ЗХАБ-ын зорилтот үр дүн, ЗХАБ-ын зорилтууд, түүнд хүрэх төлөвлөгөөг дотоод болон гадаадад сурталчлах, сурталчлах явдал юм. Байгууллагууд өөрсдийн нэвтрүүлсэн ЗХАБ-ын менежментийн тогтолцоог хэрхэн сурталчлах, мөн дээд удирдлагын тогтолцоонд тууштай байдлыг хэрхэн бэхжүүлэх талаар бодож болно.

А.7.6 Баримтжуулсан мэдээлэл

Удирдамж өгөөгүй.

А.8 Үйл ажиллагаа

А.8.1 Үйл ажиллагааны төлөвлөлт ба хяналт

Зааварчилгаа өгөөгүй.

А.8.2 Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ

Зааварчилгаа өгөөгүй.

А.9 Гүйцэтгэлийн үнэлгээ

А.9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ, үнэлгээ

Байгууллагын ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлсийг тогтоосны дараа ЗХАБ-ыг сайжруулахад түүний хувь нэмрийн талаар мэдээлэлтэй байхын тулд мониторинг хийх тогтолцоог боловсруулах шаардлагатай.

А.9.2 Зам тээврийн осол болон бусад тохиолдлын судалгаа

Зам тээврийн ослын судалгаа нь тохиолдол давтагдахаас сэргийлэх, сайжруулах боломжийг тодорхойлох чухал хэрэгсэл юм. Үүнийг мөн байгууллага дахь ЗХАБ-ын талаарх ерөнхий мэдлэгийг дээшлүүлэхэд ашиглаж болно.

Онц ноцтой/ноцтой гэж ангилагдсан зам тээврийн ослыг тодорхойлох, тэдгээрийг хэрхэн судлах талаар тодорхой бодлого, шалгуурыг тогтоох нь судалгааны тогтвортой байдлыг хангана. Ноцтой тохиолдлын талаар ахлах удирдлагад шуурхай мэдээлэх журамтай байвал зохино.

А.9.3 Дотоод аудит

Аудитыг жилд наад зах нь нэг удаа, байгууллагын нөхцөл байдал өөрчлөгдөх бүрт тогтмол хийдэг байх нь зохистой юм. Эдгээр аудит нь тухайн байгууллага менежментийн тогтолцооныхоо болон энэхүү олон улсын стандартын шаардлагыг хэр хэмжээнд хангаж байгааг харуулна.

А.9.4 Удирдлагын дүн шинжилгээ

Удирдлагын дүн шинжилгээг ЗХАБ-ын менежментийн тогтолцооны бүх элементүүд болон түүний уялдаа холбоог хамруулан, ЗХАБ-ыг сайжруулахад тогтолцооны хэрэгжилтийн үр нөлөөтэй байдлыг авч үзэх зорилгоор хийнэ. Энэхүү дүн шинжилгээг хийхдээ дээд удирдлага нь газар дээр нь очиж танилцах, талбар дээрх ажилтнууд болон сонирхогч талуудтай ярилцах замаар ойлголт, төлөв байдлыг олж авах нь чухал юм.

Байгууллага дахь ЗХАБ-ын гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээ авахын тулд дүн шинжилгээг хийх ба жилд дор хаяж нэг удаа, эсвэл байгууллагын төлөв байдалд өөрчлөлт орсон үед хийх нь зохистой дадалд тооцогдоно. Удирдлагын дүн шинжилгээнд ижил түвшний байгууллагуудтай харьцуулсан мэдээллийг хамруулж болно.

А.10 Сайжруулалт

ЗХАБ-ын менежментийн тогтолцоог тогтмол үр нөлөөтэй байлгахын тулд байгууллага нь бодит болон болзошгүй үл тохиролуудыг олж тогтоох, асуудал аль болох үүсэхээс сэргийлэх залруулах болон сэргийлэх арга хэмжээний журамтай байна.

ЗХАБ-ын менежментийн тогтолцооны гүйцэтгэлтэй холбоотой үл тохирол үүсгэж болох асуудлуудын жишээнүүдээс дурьдвал: дээд удирдлага үүрэг амлалтаа илэрхийлэхгүй байх, ЗХАБ-ын зорилтуудыг тогтоогоогүй, үүрэг хариуцлагыг тодорхойлоогүй, тогтолцоог дэмжиж, таниулаагүй, хангалттай нөөцөөр хангаагүй, тогтолцооны нийцлийг давтамжтайгаар үнэлээгүй, зам тээврийн тохиолдлыг бүртгээгүй эсхүл засч залруулах арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлээгүй, зохих

баримт бичгийг хөтлөөгүй. ЗХАБ-ын гүйцэтгэлтэй холбоотой дараах жишээнүүд байж болно:

- төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлээгүй,
- ЗХАБ-ын зорилтууд, зорилтот үр дүнд хүрээгүй, эсхүл анхаарал хандуулаагүй зам тээврийн осол, бусад тохиолдлын түвшин өндөр байна.

Ажил гүйцэтгэж байгаа хүмүүс үл тохиролыг олж илрүүлэх, болзошгүй эсвэл бодит асуудлын талаар мэдээлэхийг дэмждэг байх нь хамгийн тохиромжтой юм.

А.11 Байгууллагын янз бүрийн төлөв байдал ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлүүд

Энэхүү олон улсын стандартын шаардлагыг хангасан янз бүрийн төрөл, хэмжээтэй байгууллагууд нь ялгаатай хэмжээ, хамрах хүрээ, төвөгшлийн зэрэг бүхий ЗХАБ-ын менежментийн тогтолцоог баримтжуулж, ажиллуулах ба ингэхдээ бүгд урт хугацааны ЗХАБ-ын зорилтуудад хүрэхийг зорьсон байна.

Хүснэгт А.1-д зарим янз бүрийн төрлийн байгууллагуудын ЗХАБ-ын янз бүрийн төлөв байдал болон хамгийн их хамааралтай байж болох ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлсийг харуулсан болно. Төлөв байдал болон ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлсийг тодорхойлох нь энэхүү олон улсын стандартын гол бүрэлдэхүүн юм. Дараах жишээнүүдийг урам зоригжуулах зорилгоор танилцуулж байна.

А.1-р хүснэгт - Янз бүрийн байгууллагуудын төлөв байдал ба ЗХАБ-ын гүйцэтгэлийн хүчин зүйлс

Бараа бүтээгдэхүүн ба зорчигч тээвэр-Таксины жижиг компани	Зорчигч тээврийн үндсэн үйл ажиллагаа нь ажилтан, зорчигч ба тээвэр - харилцагч, замын хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй байдалд шууд нөлөөлдөг. Таксины компаниудын зөвлөгөө авч болох сонирхолтой талуудад үйлчлүүлэгчид (аливаа хязгаарлалтын талаар), жолооч нар (хурдны талаар) болон тээврийн хэрэгсэл худалдан авахад оролцдог (аюулгүй тээврийн хэрэгслийг сонгохтой холбоотой) болон засвар үйлчилгээ хийдэг хүмүүс (аюулгүй байдлыг хангахын тулд) багтана. Такси компанийн ЗХАБ-ын гүйцэтгэлийн гол хүчин зүйлүүдэд жолоодох чадвар (ядаргаа, архи, мансууруулах бодисын нөлөө гэх мэт), жолоодлогын хурд, жолооч болон зорчигчдын хамгаалалтын бүсний хэрэглээ, тээврийн хэрэгслийн сонголт, засвар үйлчилгээ, аяллын төлөвлөлт зэрэг багтана. Мониторинг гол хэрэгсэлд хязгаарлалтыг дагаж мөрдөх, жолооны үнэмлэхийн байдал хамаарна .
--	---

<p>Бараа бүтээгдэхүүн, зорчигч тээвэрлэлт-автомашин тээвэр</p>	<p>Арилжааны тээврийн үйлчилгээ нь дэлхийн зам дээрх нас баралтын пропорциональ бус өндөр тоог бүрдүүлдэг. Ийм зам тээврийн үйлчилгээ үзүүлэгч нь ажилчид, харилцдаг гуравдагч этгээд болон үйл ажиллагаа явуулж буй томоохон нийгэмлэгүүдийн өмнө ЗХАБ-ын хариуцлага хүлээдэг. Тэд мөн үйлчлүүлэгчдийнхээ өмнө барааг найдвартай хүргэх үүрэгтэй.</p> <p>ЗХАБ-ын гүйцэтгэлийн гол хүчин зүйлүүдэд жолоочийн сонголт, хурдны удирдлага, эрүүл мэндийн хувьд тохирсон байх зэрэг жолооч нарын зохих ур чадвар, зан төлөвтэй байхыг хэрхэн удирдаж, урам зоригжуулж байгаа байдал хамаарна. Зам тээврийн осолд өртөх, зорчигчид болон бусад хөдөлгөөнд оролцогчдын амь нас, хүнд бэртэх эрсдэлийг бууруулах зорилгоор зохион бүтээсэн, тоногосон, тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс техникийн үзлэгт хамрагдаж, засвар үйлчилгээ хийсэн байна. Ачаа сайтар бэхлэгдсэн, даац хэтрүүлээгүй зохих шаардлагын дагуу байх шаардлагатай.</p> <p>Аюулгүй аялалын төлөвлөлтөд тээвэрлэх хугацаа, хурдыг зөв тооцож, тохиромжтой замыг сонгох нь чухал юм. Замын сүлжээн дэх бусад хөдөлгөөнд оролцогчийн үйлдлийг тооцоолон, осол болсон тохиолдолд нэн даруй арга хэмжээ авахад бэлтгэлтэй байна.</p>
<p>Зорчигч болон бараа бүтээгдэхүүн тээвэрлэх үндэстэн дамнасан борлуулалт, маркетингийн байгууллага</p>	<p>Компанийн ажлаар жолоо барих нь тээврийн хэрэгслийн бүс нутаг эсвэл дэлхийн паркийг ажиллуулдаг үндэстэн дамнасан компаниудын хувьд хамгийн эрсдэлтэй үйл ажиллагаа юм.</p> <p>Борлуулалт, үйлчилгээний болон бусад жолооч нар нийт ажлын цагийн 40-60 хувийг компанийн эзэмшлийн, түрээсийн, ажлын болон бусад тээврийн хэрэгслээр компанийн үйл ажиллагаанд зарцуулдаг. Тиймээс аж ахуйн нэгжүүд ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй;</p> <p>Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдэд нас барах, гэмтэх зэрэг паркийн аюулгүй байдлын эрсдэлийг ойлгох, автомашин болон жолооч нарын автозамын сүлжээнд зохих ёсоор орох, гарах, хурд, архи, бүс, малгай хэрэглэх, жолооч ядрах, анхаарах сарних, тээврийн хэрэгслийн сонголт/засвар үйлчилгээ багтана;</p>

	<p>Аялалын төлөвлөлт; гэрээт/дистрибьютерийн ЗХАБ-ын менежмент; болон замын аюулгүй байдлын талаарх өмгөөлөл болон замын аюулгүй байдлын нийгмийн санаачлагыг хэрэгжүүлэ замаар байгууллагын нийгмийн хариуцлагыг хангах.</p>
<p>Эрэлт хэрэгцээ үүсгэж байгаа замын хөдөлгөөн - А сургууль</p>	<p>ЗХАБ-ыг хангах нь сургуулийн үндсэн ажил биш ч, төлөвшил болон өртөлтийн хувьд эмзэг бүлгийн хэрэглэгчид өдөр бүр сургууль руу явах, буцах олон аялал хийдэг. Зам тээврийн осол нь сургуулийн насны хүүхдүүдийн нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. Сургуулийн сонирхогч талуудад ажилтнууд/оюутан/эцэг эх, орон нутгийн зам, төлөвлөлтийн байгууллага болон тээврийн операторууд (аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөрт хамрагдах шаардлагатай байж болно) багтана. Сургуулийн ЗХАБ-ын гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдэд сургууль руугаа явах, буцах болон сургуулийн аялалд явах янз бүрийн хэлбэрүүд, эдгээрт аюулгүй аяллыг төлөвлөх, хамгаалалтын тохирсон хэрэгсэл (дуулга, хамгаалах бүс гэх мэт) болон үзэгдэх орчны хэрэгсэл (гэрэл цацруулагч хувцас, гэрэл гэх мэт)-ийг ашиглах зэргийг багтаана.</p>
<p>Замын хөдөлгөөний эрэлтийг бий болгох-Дэлгүүр</p>	<p>Аюултай ачаа (түлш гэх мэт) тээвэрлэх, үйлчлүүлэгчдэд гэрт бараа хүргэх, супермаркетуудыг бараа бүтээгдэхүүнээр хангах зэрэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд шууд нөлөөлдөг. Томоохон супермаркетууд нь ажилтнууд болон үйлчлүүлэгчиддээ нөлөөлж болох аюулгүй байдлын хүчин зүйлсийг авч үзнэ. Сонирхсон талуудад хариуцлагатай төлөвлөлт, замын байгууллагууд, бараа хүргэлтийн компаниуд оролцоно.</p> <p>Томоохон супермаркетуудын анхаарах гол зүйлүүдэд талбайн ойр орчмын аюулгүй байдалд түүний үзүүлэх нөлөө, автомашины зогсоол (явган зорчигч, хүүхэд, том, бага оврын тээврийн хэрэгслийн холимог хэрэглээг багтаасан) болон зам руу шууд орох, гарах хэсэг аль алинд нь үйлчлүүлэгчдэд аюулгүй орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах бүх хүчин зүйлүүд орно.</p> <p>Замын дэд бүтцийн аюулгүйн төлөвлөлт, зураг төсөл, ашиглалт, хэрэглээ, жолооч нарын хувийн хамгаалалтын хэрэгслийг ашиглах, аюулгүй жолоодлогын хурд, хүргэлт</p>

	хийж буй тээврийн хэрэгслийн төрөл зэрэг гүйцэтгэлийн олон хүчин зүйл хамааралтай байж болно.
Замын төсөл, ашиглалт-Замын эрх бүхий байгууллага	<p>Замын сүлжээг бий болгох үндсэн чиг үүрэг нь тухайн сүлжээний бүх хэрэглэгчдийн аюулгүй байдалд шууд нөлөөлдөг. Орон нутгийн автозамын эрх бүхий байгууллагын сонирхогч талуудад инженерийн зураг төсөл боловсруулдаг, ашиглалтын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд (аюулгүй байдлыг шаардлагатай түвшинд хангах чадвартай байна), томоохон хэрэглэгчдийн бүлгүүд (аюулгүй ашиглах шаардлагыг хүлээн зөвшөөрөх хэрэгцээтэй хүмүүс), хяналтын байгууллагууд (хэрэглэгч/тээврийн хэрэгслийн стандартыг мөрдүүлэх, сүлжээний аюулгүй байдлын нэмэлт шаардлагыг тогтоох хүмүүс) хамаарна.</p> <p>Замын эрх бүхий байгууллагын ЗХАБ-ын гүйцэтгэлийн гол хүчин зүйлүүдэд авто замын сүлжээний аюулгүй төлөвлөлт, зураг төсөл, ашиглалт, хэрэглээний ангилалд багтдаг бүх хүчин зүйлүүд хамаарна. Үүнд замын хөдөлгөөнд оролцогчдын хажуугийн, эсрэг талын болон эмзэг хэсгийн хамгаалалтын түвшин, холбогдох хурдны хязгаар, мөн хэрэглэгчийн нийцтэй байдал зэрэг хүчин зүйлс багтаж болно. Сүлжээний менежментийн илүү өргөн хүрээнд шинжилгээ хийх, хэрэгжилтийн тайланд мониторингийн хэрэгслүүдийг нэгтгэж болно.</p>

Хавсралт Б

(мэдээллийн)

Замын хөдөлгөөнийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоотой холбоотой олон улсын хэмжээнд хийгдэж байгаа ажил

В.1 Ерөнхий зүйл

Энэхүү олон улсын стандарт нь байгууллага бүрт өөрийн гэсэн ЗХАБ-ын менежментийн тогтолцоог боловсруулахад зориулсан ерөнхий журам, шаардлагыг хангах замаар ЗХАБ-ыг сайжруулах дэлхийн дээр авч байгаа чухал арга хэмжээ юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Аюулгүй тогтолцооны аргыг ойлгох нь энэхүү олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлэх үндсэн суурь юм.

Энэхүү хавсралтад Аюулгүй тогтолцооны үндсэн элементүүдийг тоймлохоос гадна энэ чиглэлээр зохистой дадалд нийцсэн ЗХАБ-ын менежментийн тогтолцоог

хэрэгжүүлэх талаар байгууллагуудад нэмэлт удирдамжийг өгсөн

В.2 ЗХАБ-ын аюулгүй тогтолцооны арга

Энэхүү олон улсын стандартыг нийтлэх үед хэд хэдэн улс орнууд ЗХАБ-ын хөтөлбөрөө боловсруулж хэрэгжүүлэхэд Аюулгүй тогтолцооны аргыг ашиглаж байна. Швед улс "Ослыг тэглэх алсын хараа", Нидерланд улсад нягт холбоотой "Тогтвортой аюулгүй байдал" аргыг боловсруулсан, Шинэ Зеланд болон Австралийн хэд хэдэн хууль эрх зүйн орчинд Аюулгүй тогтолцооны далбаан дор хөтөлбөрүүдийг бий болгосон.

Тодорхой онцлог зүйлс ялгаатай байдаг ч Аюулгүй тогтолцоо нь ихэвчлэн:

а) зам тээврийн ослын шалтгаантай нас баралт, хүнд гэмтлийг арилгах урт хугацааны зорилготой байх;

б) хүний буруутай үйлдлийг илүү сайн тооцсон замын хөдөлгөөний тогтолцоог хөгжүүлэх зорилготой. Үүнийг тухайн нэг замын хэрэглэгч нас барах эсвэл хүнд гэмтэлд хүргэх мөргөлдөөний хүчинд дангаараа өртөхгүй байхаар мөргөлдөөний хүчийг илүү сайн удирдах замаар ихэвчлэн хийдэг;

в) ослын хүчийг илүү сайн удирдах олон стратегийг нэгтгэх ба үүнд гол стратеги нь замын дэд бүтцийн хамгаалалтын түвшинд тохирсон хурдны хязгаартай уялдуулан замын сүлжээг сайжруулах явдал юм;

г) Гэмтлийн асуудлын цар хүрээг ойлгохын тулд эдийн засгийн нарийн дүн шинжилгээ хийх, нийгэмд хамгийн их ашиг тусаа өгөх хөтөлбөр, байршилд шууд хөрөнгө оруулалт хийх;

д) замын хөдөлгөөний тогтолцооны аюулгүй ажиллагааг тодорхойлох үүрэгтэй төрийн бүх гол болон бусад байгууллагуудыг багтаасан манлайлал, менежмент, мэдээлэл харилцааны бүтэцтэй байх;

е) эдийн засгийн зорилго, хүний болон хүрээлэн буй орчны эрүүл мэндийн зорилгыг хангах аюулгүй байдлын менежментийн шийдвэр гаргалтыг нийгмийн өргөн хүрээний шийдвэр гаргалттай уялдуулж, замын хөдөлгөөний аюулгүй бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт болон ашиг тусыг нэмэгдүүлэх арилжааны орчныг бүрдүүлэх;

г) иргэд, төр, хувийн болон ашгийн бус байгууллагуудын дунд аюулгүй байдлын эцсийн зорилго, түүнд хэрхэн хүрэх талаар нийтлэг үзэл бодолтой байхын тулд замын хөдөлгөөний тогтолцооны янз бүрийн оролцогчдын хүрээнд ЗХАБ-ын талаар "хамтын хариуцлага" ёс зүйг хүлээн зөвшөөрөх.

Эдгээр аргыг замын хөдөлгөөнтэй холбоотой үйл ажиллагаагаар ЗХАБ-д нөлөөлдөг бүх төрийн болон хувийн байгууллагуудад хэрэглэх боломжтой ба холбогдох ЗХАБ-ын менежментийн тогтолцооны хэмжүүрийг тодорхойлоход тусалдаг.

В.3 ЗХАБ-ын менежментийн чиглэлээр олон улсын ажил

Замын хөдөлгөөний аюулгүй байдал хангалтгүй байгаа нь дэлхийн улс орнуудад дарамт болж байна. Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) нь 2004 оны "Зам тээврийн

ослоос сэргийлэх дэлхийн тайлан"[9], ДЭМБ-ын 2009 оны "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх дэлхийн төлөв байдлын тайлан"[10]-г гаргасан Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) болон Дэлхийн Банкныг даган ЗХАБ-ын чиглэлээр тодорхой алхам хийсэн.

2010 оны 3-р сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2011-2020 оныг 2020 он гэхэд дэлхий даяар зам тээврийн ослоор нас баралтын түвшинг тогтворжуулах, бууруулах зорилттойгоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын 10 жил болгон зарласан. 2011 онд хэвлэгдсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын 10 жилийн үйл ажиллагааны дэлхийн төлөвлөгөөнд тодорхойлсон таван тулгуур багана (замын аюулгүй байдлын менежмент, аюулгүй зам ба хөдөлгөөн, аюулгүй тээврийн хэрэгсэл, аюулгүй замын хөдөлгөөнд оролцогчид, ослын дараах хариу арга хэмжээ)-ын эхнийхийг энэхүү олон улсын стандартын тусламжтай хэрэгжүүлэх боломж бий.

2008 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Олон улсын замын хөдөлгөөний форум хамтран "Тэг рүү: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын амбицтай зорилтууд ба аюулгүй тогтолцооны арга" номыг нийтэлсэн[11]. Энэхүү тайланд ЗХАБ-ын менежментийн тогтолцооны ач холбогдлыг тэмдэглэж, Дэлхийн Банкны Замын Аюулгүй Байдлын байгууллага (WBGRSF)-аас боловсруулж, 2009 онд нийтэлж кодолсон менежментийн тогтолцоог иш татсан. WBGRSF-ийн хэвлэлд ЗХАБ-ын менежментийн тогтолцоог хөгжүүлэхэд зориулсан ЗХАБ-ын хууль тогтоомжийн амжилттай хэрэгжүүлсэн туршлагаудад хийсэн дүн шинжилгээний цогц судалгаатай танилцах боломжтой (Зураг В.1-ийг үзнэ үү).

Энд байгууллагын бүтэц, соёлын асуудлыг хөндөхгүй харин байгууллагын менежментийн чиг үүрэг, хөндлөнгийн оролцоо ба үр дүн бүхий хоорондоо холбоотой гурван элементийг танилцуулсан.



Эх сурвалж: Bliss and Vreen газрын Тээврийн аюулгүй байдлын хүрээнд баригдсан, 2000 Вегман, 2001, Коорнстра нар

Зураг Б.1 - Дэлхийн банкны дэлхийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын байгууллагын замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хүрээ

WBGRSF-ийн тогтолцоо нь амжилттай ЗХАБ-ын менежментийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон хэрэгжүүлэх шаардлагатай байгууллагын менежментийн дараах чиг үүргийг тодорхойлсон.

а) үр дүнд анхаарлаа төвлөрүүлэх: бүх үйл ажиллагаа, хөндлөнгийн оролцоог удирдан чиглүүлдэг ЗХАБ-ын гүйцэтгэл, хариуцлагын талаархи байгууллагын хүсэл тэмүүлэлийн тухай мэдэгдэл;

б) Зохицуулалт: Байгууллага дотор (дотоод) болон хөндлөн чиглэлд буюу ЗХАБ-д үүрэг, сонирхол бүхий холбогдох байгууллагуудад хөндлөнгийн оролцоог зохицуулах, уялдуулах;

в) хууль тогтоомж: байгууллагын хариуцлага болон түүнчлэн газар ашиглалт, замын сүлжээ, замын хэрэглэгч, тээврийн хэрэгсэл, ослын дараах эмнэлгийн тусламжийн аюулгүй байдлын стандарт, дүрэм бүхий хууль эрх зүйн болон бодлогын арга хэрэгслийн тодорхойлолт ба/эсвэл тэдгээрт нийцэж байгаа эсэх;

